

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
СОНГУУЛИЙН ТУХАЙ**
/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорхойлж, иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хангах, сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн
тухай хууль тогтоомж**

2.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."сонгогч" гэж сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэнийг;

3.1.2."сонгуулийн эрх бүхий иргэн" гэж арван найман насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг;

3.1.3."арван найман насанд хүрсэн" гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг;

3.1.4."хорин таван насанд хүрсэн" гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгууль товлон зарлах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг;

¹ Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

3.1.5."иргэний эрх зүйн бүрэн чадамж" гэж Иргэний хуулийн 15.1-д заасныг;

3.1.6."аль нэг намын гишүүн" гэж аль нэг улс төрийн намд гишүүнээр элсч бүртгүүлсэн бөгөөд тухайн намын дүрмийн дагуу гишүүнээс гараагүй иргэнийг;

3.1.7."төрийн өмчит хуулийн этгээд" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн² 13, 15 дугаар зүйлд заасан төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газрыг;

3.1.8."төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг.

4 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын сонгууль

4.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хуралд 76 гишүүнийг сонгох бөгөөд ингэхдээ сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэлд болон бие даан нэр дэвшигчид өгсөн саналын тоонд хувь тэнцүүлэн сонгоно.

4.2.Монгол Улсын Их Хурлын 76 гишүүнийг олон мандаттай нэг тойргоос сонгоно.

5 дугаар зүйл.Монгол Улсын сонгуулийн үндсэн зарчим

5.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгох эрхийг хангахад үндэслэнэ.

5.2 Монгол Улсын Их Хурлын сонгууль /цаашид "сонгууль" гэх/ бүх нийтийн байх бөгөөд түүнд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд /цаашид "сонгуулийн эрх бүхий иргэн" гэх/ үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр эрх тэгш байдлын үндсэн дээр оролцох эрхтэй.

5.3.Сонгууль нь шууд байх бөгөөд түүнд сонгогч, сонгогдогч ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, шууд сонгох ба сонгогдоно.

² Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 11 дүгээрт нийтлэгдсэн.

5.4. Сонгууль нь чөлөөтэй бөгөөд сонгогчоос сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.

5.5. Сонгогч саналаа нууцаар өгөх бөгөөд хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж саналаа өгөх боломжоор хангагдсан байна.

5.6. Энэ хуульд заасан шаардлагыг хангасан хорин таван нас хүрсэн сонгуулийн эрх бүхий иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхтэй.

5.7. Монгол Улсын иргэн /цаашид “иргэн” гэх/-ий сонгох, сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлахыг хориглоно.

5.8. Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр нотлогдсон, хорих газар ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй.

5.9. “Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр нотлогдсон” гэж Монгол Улсын Иргэний хуулийн³ 18.2 дахь хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн⁴ 141-143 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүхээс иргэнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцсоныг;

5.10. “Хорих газар ял эдэлж байгаа” гэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор хорих ял эдэлж байгаа иргэнийг ойлгох бөгөөд үүнд хорих ял эдлэхээс зайлсхийж яваа, хорих байгууллагаас түр чөлөөгөөр гарсан иргэнийг нэгэн адил хамааруулна.

5.11. Гадаадад түр болон удаан хугацаагаар зорчиж яваа дипломат төлөөлөгчийн болон консулын газарт бүртгэлтэй Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцох эрхтэй.

5.12. Сонгогчоос энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан эрхээ хэрэгжүүлэхэд аливаа хэлбэрээр санаатайгаар саад учруулсан иргэнийг 150000-180000 төгрөгөөр, албан тушаалтныг 200000-300000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 5000000-10000000 төгрөгөөр торгоно.

6 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрх

6.1. Энэ хуулийн 23.1-д заасан нам буюу намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэнэ/ Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.

6.2. Сонгогдох эрх бүхий иргэн өөрийн байнга оршин суугаа аймаг, нийслэлийн хүн амын бүртгэлд бүртгэгдсэн сонгуулийн эрх бүхий 801-ээс доошгүй иргэний дэмжлэг авсан нөхцөлд Улсын Их Хурлын гишүүнд нэрээ бие даан дэвшүүлэх эрхтэй.

³ Иргэний хууль - “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн

⁴ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн

7 дугаар зүйл. Сонгууль зарлах

7.1. Сонгуулийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал товлон зарлана.

7.2. Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдөр нь сонгуулийн жилийн зургадугаар сарын сүүлийн хагасын аль нэг Лхагва гариг байна.

7.3. Санал авах өдөр бүх нийтээр амарна.

7.4. Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсгийг нь хамарсан гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, дайны ба нийтийн эмх замбараагүй байдал үүссэн зэрэг онцгой нөхцөлийн улмаас энэ хуулийн 7.2-т заасан өдөр санал авах боломжгүй бол Улсын Их Хурал энэхүү онцгой нөхцөл арилмагц сонгуулийг товлон зарлаж, санал авах өдрийг тогтоож, тогтоол гаргана.

7.5. Хэрэв Улсын Их Хурал сонгууль товлон зарласан шийдвэр батлан гаргаснаас хойш дээр дурдсан онцгой нөхцөл байдал үүссэн бол Улсын Их Хурал тухайн сонгуулийн санал авах өдрийг тодорхой хугацаагаар хойшлуулах шийдвэр гаргах, эсхүл сонгууль зарласан шийдвэрээ цуцалж, уг нөхцөл байдал арилсны дараа сонгууль зарлах асуудлыг шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл. Сонгуулийн ажлын ил тод байдал

8.1. Сонгууль зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдуулан сонгуулийн хороодоос энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд нийтээр дагаж мөрдүүлэхээр батлан гаргасан шийдвэр нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд албан ёсоор мэдээлэгдсэн байна.

8.2. Сонгууль бэлтгэн явуулах ажил ил тод байх бөгөөд энэ нь сонгуулийн үйл ажиллагааны явцад хуулиар тогтоосон нууцыг хамгаалахад хамаарахгүй.

8.3. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон ийм үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага сонгуулийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодитой мэдээлэл түгээх үүрэгтэй.

8.4. Энэ хуулийн 8.1-д заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, ажилтныг 200000-300000 төгрөгөөр, 8.3-д заасныг зөрчсөн хэвлэл, мэдээллийн байгууллагыг 5000000-10000000 төгрөгөөр, албан тушаалтныг 250000-350000 төгрөгөөр торгоно.

9 дүгээр зүйл. Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа

9.1. Сонгууль зохион байгуулж явуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

9.1.1.сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны зардал, сонгогч, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч болон сонгуулийн ажиглагчийн үнэмлэх, түүнчлэн саналын хуудас, бие даан нэр дэвшигчийг дэмжигч сонгуулийн эрх бүхий иргэний гарын үсэг цуглуулах маягт, сонгогчдын нэрийн жагсаалт, сонгуулийн дүн, мэдээний маягт, сонгуулийн аймаг, нийслэлийн болон салбар, хэсгийн хороодын албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг, лац, санал авах ажиллагаанд хэрэглэх программ хангамж, техник тоног төхөөрөмж, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл болон тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хамгаалах, хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх зардал;

9.1.2.саналын хайрцаг хийх, сонгуулийн хэсгийн хороодын ажиллах болон санал авах байрыг тохижуулах зардал;

9.1.3.сонгуулийн тухай хууль тогтоомж болон сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын авлага хэвлэх, хүргэх зардал;

9.1.4.сонгуулийн аймаг, нийслэлийн болон салбар, хэсгийн хороодын ажилтнуудын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал;

9.1.5.сонгуулийн тухай хууль тогтоомжийг сурталчлах болон сонгуулийн бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал;

9.1.6.нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт, зарцуулалтыг хянан шалгахад гарах зардал;

9.1.7.дахин санал авах, дахин сонгууль явуулах зардал;

9.1.8.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;

9.1.9.Сонгуулийн ерөнхий хороо, аймаг, нийслэлийн болон салбар, хэсгийн хороодын орон тооны бус гишүүний тухайн хороонд ажилласан хугацааны ажлын хөлс, урамшуулал, хоолны зардал, хуульд өөрөөр заагаагүй бол сонгуулийн хорооны гишүүн сонгуулийн ажил үүргээ гүйцэтгэж явах үедээ эрүүл мэнд нь хохирсон, амь насаа алдсан тохиолдолд олгох нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламжийн зардал;

9.1.10.Сонгуулийн ерөнхий хороо, аймаг, нийслэлийн болон салбар, хэсгийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал;

9.1.11.Улсын Их Хурлаас тогтоосон бусад зардал.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг иргэний бүртгэлийн байгууллагаас гаргасан хүн амын тоонд түшиглэн Сонгуулийн ерөнхий хорооноос тооцон гаргасан саналыг үндэслэн Улсын Их Хурал тухай бүр батална.

9.3.Сонгуулийн аймаг, нийслэлийн болон салбар, хэсгийн хороодын ажиллах, санал авах байрыг төр, орон нутгийн өмчийн болон түүний оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгнө.

9.4.Сонгуулийн аймаг, нийслэлийн болон салбар, хэсгийн хороодын ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга хариуцна.

9.5.Энэ хуулийн 9.3-т заасныг зөрчсөн хуулийн этгээдийг 5000000-10000000 төгрөгөөр, албан тушаалтныг 250000-350000 төгрөгөөр, 9.4-т заасныг зөрчсөн Засаг даргыг 200000-300000 төгрөгөөр торгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ **Сонгуулийн нутаг дэвсгэрийн** **зохион байгуулалт**

10 дугаар зүйл.Сонгуулийн нутаг дэвсгэрийн хуваарь

10.1.Сонгуулийн нутаг дэвсгэр нь Монгол Улсын нутаг дэвсгэр байна.

10.2.Монгол Улсын нутаг дэвсгэр нь сонгуулийн нэг тойрог болно.

10.3.Сонгуулийн тойрог нь сонгуулийн хэсэг /цаашид "хэсэг" гэх/-үүдэд хуваагдана.

11 дүгээр зүйл.Хэсэг, түүнийг байгуулах

11.1.Сонгогчдын санал авч тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид хэсгийг санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарлана.

11.2.Сонгуулийн нэг хэсэг нь суманд 2000, аймгийн төвд 3000, нийслэлийн дүүрэгт 4000-аас илүүгүй сонгогчтой байна.

11.3.Гадаад улсад хууль ёсоор оршин суугаа Монгол Улсын иргэдийн саналыг авах хэсэг байгуулах журмыг Сонгуулийн ерөнхий хороо гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

11.4.Нэгэнт байгуулагдсан хэсгийн сонгогчдыг онцгой нөхцөлийн улмаас тухайн хэсгээс тусгаарлах, хэсгийг нэгтгэх, шинээр байгуулах асуудлыг санал авах өдрөөс 7-оос доошгүй хоногийн өмнө шийдвэрлэж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ **Сонгуулийн байгууллага, түүний зохион** **байгуулалт, бүрэн эрх**

12 дугаар зүйл.Сонгуулийн байгууллагын тогтолцоо

12.1.Сонгуулийн байгууллагын тогтолцоо нь сонгуулийн төв, орон нутгийн байгууллагаас бүрдэнэ.

12.2.Сонгуулийн төв байгууллага нь Сонгуулийн ерөнхий хороо, орон нутгийн байгууллага нь сонгуулийн аймаг, нийслэлийн хороо /цаашид “аймаг, нийслэлийн хороо” гэх/, аймаг, нийслэлийн салбар хороо /цаашид “салбар хороо” гэх/, сонгуулийн хэсгийн хороо /цаашид “хэсгийн хороо” гэх/ байна.

12.3.Сонгуулийг Сонгуулийн ерөнхий хороо, аймаг, нийслэлийн болон салбар, хэсгийн хороо эрхлэн явуулна.

12.4.Сонгуулийн ерөнхий хороо нь улсын хэмжээнд, аймаг, нийслэлийн хороо нь тухайн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд, аймаг, нийслэлийн салбар хороо нь тухайн аймгийн сум, нийслэлийн дүүргийн хэмжээнд, хэсгийн хороо нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухайн нэгжид тус тус сонгуулийн үйл ажиллагааг эрхлэн зохион байгуулж явуулна.

12.5.Сонгуулийн хороод нь шатлан захирагдах зарчмаар ажиллах ба дээд шатны хорооны хууль ёсны шийдвэрийг доод шатны нь хороо заавал биелүүлэх бөгөөд доод шатны хорооны хууль бус шийдвэрийг дээд шатны нь хороо хүчингүй болгох эрхтэй.

12.6.Сонгуулийн аймаг, нийслэлийн болон салбар, хэсгийн хороодын бүрэлдэхүүнд зөвхөн төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг томилон ажиллуулна.

12.7.Сонгуульд оролцогч аль нэг нам, эвслийн төлөөлөл, төрийн улс төрийн албан тушаалтан, шүүгч, Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигч нь сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд орохыг хориглоно.

12.8.Сонгуулийн аймаг, нийслэлийн болон салбар, хэсгийн хороод байгуулагдсан өдрөөс эхлэн Сонгуулийн ерөнхий хороо аймаг, нийслэлийн хорооны, аймаг, нийслэлийн хороо харьяалах салбар, хэсгийн хороодын үйл ажиллагааг дуусгавар болгох хүртэлх хугацаанд өөрсдийн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

12.9.Сонгуулийн аймаг, нийслэлийн болон салбар, хэсгийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүн аль нэгэн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулах, энэ зорилгоор сонгогчоос сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд, түүнчлэн санал хураах, тоолох ажилд санаатайгаар саад хийх, бусдыг төлөөлж санал өгөх, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг болон санал тоолох төхөөрөмжийн лац, битүүмжлэлийг гэмтээх, гарын үсэг хуурамчаар үйлдэх, саналын хуудас солих, хүчингүй саналын хуудсаар санал авах зэрэг хууль бус аливаа үйлдлийг зохион байгуулах, өөгшүүлэх, бусад хэлбэрээр дэмжихийг хориглоно.

12.10.Сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь Улсын Их Хурлаас баталсан Сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.

12.11.Сонгуулийн хороодоос сонгуулийг зохион байгуулах, сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгахад төрийн албан хаагч, нэр дэвшигч, сонгуульд оролцож байгаа нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, ухуулагч, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч хөндлөнгөөс оролцох, саад учруулахыг хориглоно.

12.12.Сонгууль зохион байгуулж явуулах хугацаанд аймаг, нийслэлийн болон салбар, хэсгийн хороодын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд дээд шатны сонгуулийн хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглоно.

12.13.Сонгууль бэлтгэн явуулахад төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу оролцоно.

12.14.Энэ хуулийн 12.9-д заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг 250000-300000 төгрөгөөр торгож, сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах бөгөөд түүнийг бүрэлдэхүүнээс хасах асуудлыг дээд шатны сонгуулийн хороо хэлэлцэж шийдвэрлэнэ.

12.15.Энэ хуулийн 12.9-д заасан зөрчил гаргасан нь холбогдох этгээдийг 1 жилийн хугацаагаар эргэж орох нөхцөлгүйгээр төрийн албанаас халах үндэслэл болох бөгөөд зохих хороо нь хууль зүйн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

12.16.Энэ хуулийн 12.12-т заасныг зөрчсөн төрийн албан хаагчид Цагдаагийн байгууллагын тухай⁵, Прокурорын байгууллагын тухай⁶, Шүүхийн тухай⁷ хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

13 дугаар зүйл.Сонгуулийн ерөнхий хороо, түүний бүрэн эрх

13.1.Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төв байгууллага мөн.

13.2.Сонгуулийн ерөнхий хорооны эрх зүйн байдал, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хуулиар тогтооно.

14 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн хороо, түүний бүрэн эрх

14.1.Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн хороог дарга, нарийн бичгийн дарга, 7-13 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, улсын хэмжээнд нийтэд мэдээлнэ.

⁵ Цагдаагийн байгууллагын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1993 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Прокурорын байгууллагын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 29 дүгээрт нийтлэгдсэн.

⁷ Шүүхийн тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 29 дүгээрт нийтлэгдсэн.

14.2.Аймаг, нийслэлийн хороо нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.2.1.сонгууль бэлтгэн явуулах ажлыг төлөвлөх, сонгуулийн үйл явцыг зохион байгуулах бүхий л арга хэмжээг авах;

14.2.2.сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах;

14.2.3.харьяалах салбар болон хэсгийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн талаар нэгтгэн удирдах;

14.2.4.харьяалах хэсгийн хороодын нэгдсэн дугаарыг тогтоох;

14.2.5.Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах салбар болон хэсгийн хороодод хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

14.2.6.сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон асуудлаар харьяалах салбар, хэсгийн хороо, түүнчлэн тухайн нутаг дэвсгэрийн зохих шатны төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдах албан тушаалтны мэдээллийг сонсож, шаардлагатай арга хэмжээ авах;

14.2.7.харьяалах салбар болон хэсгийн хорооны шийдвэрийн талаархи өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж бичгээр хариу өгөх;

14.2.8.санал тоолсон дүнгийн тухай харьяалах салбар болон хэсгийн хорооны шийдвэрийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн хэмжээний сонгуулийн дүнг нэгтгэн Сонгуулийн ерөнхий хороонд хүргэх, олон нийтэд мэдээлэх;

14.2.9.дахин санал авах, дахин сонгууль явуулах ажлыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;

14.2.10.сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу цэгцлэн архивлаж, Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгөх;

14.2.11.Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн үүргийг биелүүлэх;

14.2.12.хуульд заасан бусад бүрэн эрх.

14.3.Аймаг, нийслэлийн хороо харьяалах салбар, хэсгийн хорооны хууль тогтоомжид нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгоно.

15 дугаар зүйл.Салбар хороо, түүний бүрэн эрх

15.1.Аймаг, нийслэлийн хороо нь суманд, шаардлагатай бол нийслэлийн дүүрэгт салбар хороог санал авах өдрөөс 50-иас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, 5, эсхүл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

15.2.Салбар хороо нь өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд энэ хуулийн 14.2.1, 14.2.2, 14.2.6-д заасан бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.2.1.харьяалах сонгуулийн хэсгийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн талаар нэгтгэн удирдах;

15.2.2.аймаг, нийслэлийн хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, харьяалах сонгуулийн хэсгийн хороодод зохих журмын дагуу хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

15.2.3.өөрт харьяалах өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж хариуг өгөх;

15.2.4.санал тоолсон дүнгийн тухай харьяалах хэсгийн хорооны шийдвэрийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн хэмжээгээр сонгуулийн дүнг нэгтгэж, зохих аймаг, нийслэлийн хороонд хүргэх, олон нийтэд мэдээлэх;

15.2.5.дээд шатны сонгуулийн хороодоос өгсөн үүргийг биелүүлэх;

15.2.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

15.3.Салбар хороо нь сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу цэгцэлж, харьяалах аймаг, нийслэлийн хороонд хүлээлгэн өгнө.

16 дугаар зүйл.Хэсгийн хороо, түүний бүрэн эрх

16.1.Аймаг, нийслэлийн хороо хэсгийн хороог санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

16.2.Хэсгийн хорооны бүрэлдэхүүний тоог сонгогчдын тоо, ажлын хэмжээг харгалзан дор дурдсанаар тогтооно:

16.2.1.тухайн хэсэгт 2000 хүртэл сонгогчтой бол 9, эсхүл 11;

16.2.2.тухайн хэсэгт 2001-3000 хүртэл сонгогчтой бол 11, эсхүл 13;

16.2.3.тухайн хэсэгт 3001-ээс дээш сонгогчтой бол 13, эсхүл 15.

16.3.Хэсгийн хорооны бүрэлдэхүүнд улсын бүртгэлийн албаны ажилтанг оруулна.

16.4.Хэсгийн хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.4.1.хэсгийн хорооны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;

16.4.2.сонгогчийн үнэмлэх олгох;

16.4.3.сонгогчийг шилжүүлэх, шилжиж ирсэн сонгогчийг бүртгэх;

16.4.4.сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хэмжээнд үнэн зөв нэгтгэж, сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, оршин суугаа газрын хаяг зэргийг нягтлан шалгах;

16.4.5.санал авах байр, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг болон санал тоолох төхөөрөмж зэрэг санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;

16.4.6.санал тооллогын дүн гаргаж, салбар хороонд, салбар хороогүй бол аймаг, нийслэлийн хороонд нэн даруй хүргэх;

16.4.7.сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу цэгцэлж, салбар хороонд, салбар хороогүй бол аймаг, нийслэлийн хороонд хүлээлгэн өгөх;

16.4.8.сонгууль бэлтгэн явуулах болон санал авах, санал тоолохтой холбогдсон асуудлаар гарсан өргөдөл, гомдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжлах;

16.4.9.дээд шатны сонгуулийн хорооноос өгсөн үүргийг биелүүлэх;

16.4.10.хуульд заасан бусад бүрэн эрх.

17 дугаар зүйл.Сонгуулийн хороодын ажлын зохион байгуулалт

17.1.Сонгуулийн хороод эрх хэмжээнийхээ асуудлыг хамтран хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.

17.2.Хуралдаанд гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон бол тухайн хорооны хуралдаан хүчинтэйд тооцогдоно.

17.3.Энэ хуулийн 17.1-д заасан тогтоолд тухайн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

17.4.Энэ хуулийн 17.1, 17.2-т зааснаар тухайн хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон хуралдаанаас гарсан шийдвэр хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналд үндэслэгдсэн бол энэ шийдвэрийг баталгаажуулсан тогтоолд хорооны дарга, эсхүл нарийн бичгийн дарга гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

17.5.Сонгуулийн хороод хуралдаанаараа дэгээ тогтоон батлах бөгөөд түүнд үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, гишүүдийн ажил үүргийн хуваарь, ажиллах зарчим, журмыг тусгасан байна.

17.6.Сонгуулийн хороодын хуралдааны шийдвэрийг нийтэд ил тод мэдээлнэ.

17.7.Сонгуулийн хороодын хуралдааны тэмдэглэлийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу заавал хөтлөх бөгөөд түүнийг тухайн хорооны нэг гишүүнд хариуцуулна.

17.8.Сонгуулийн баримт бичиг бүртгэлтэй байх бөгөөд түүнд хамаарах баримт бичиг, түүнийг бүртгэх журмыг Сонгуулийн ерөнхий хороо тогтооно.

17.9.Аймаг, нийслэлийн болон салбар хорооны дарга нь дотоод ажлын асуудлаар захирамж гаргана.

17.10.Сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг ажлын шаардлагыг харгалзан үндсэн ажлаас нь түр чөлөөлөн ажиллуулна. Энэ хугацааны үндсэн цалинг ажлын газар, байгууллагаас нь олгоно.

17.11.Сонгуулийн хороод сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон, түүнчлэн хууль зөрчсөн тухай асуудлыг шалгуулах, эсхүл зөрчлийг таслан зогсоох асуудлаар сонгуулийн тухай хууль тогтоомжоор үүрэг хүлээсэн аливаа байгууллага, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавих эрхтэй бөгөөд түүнийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан ажлын хоёр өдрийн дотор шийдвэрлэж, хариу мэдэгдэнэ.

17.12.Сонгуулийн ерөнхий хороо болон аймаг, нийслэлийн хороо хуваарилагдсан төсвийн хөрөнгийн хэмжээнд сонгуулийг бэлтгэн явуулахдаа хувь хүн, хуулийн этгээдтэй сонгон шалгаруулалтгүйгээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулна. Энэхүү үйл ажиллагаа нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах журмын тухай” хуулийн зохицуулалтад хамаарагдахгүй.

17.13.Төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүнчлэн аж ахуйн нэгж байгууллага нь Улсын Их Хурлын сонгуулийг бэлтгэн явуулахад энэ хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд оролцож сонгуулийн зохих шатны хорооноос тавьсан хууль ёсны шаардлагыг хангаж тэдгээрийн ажилд туслах үүрэгтэй.

17.14.Сонгуулийн хороодоос бүрэн эрхийнхээ дотор гаргасан шийдвэрийг сонгуулийн тухай хууль тогтоомжид заасны дагуу үүрэг хүлээсэн тухайн нутаг дэвсгэрийн бүх байгууллага, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.

17.15.Энэ хуулийн 17.11, 17.14-т заасныг зөрчсөн иргэнийг 150000-200000 төгрөгөөр, албан тушаалтныг 200000-300000 төгрөгөөр, байгууллагыг 5000000-10000000 төгрөгөөр торгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ **Сонгогчдын нэрийн жагсаалт**

18 дугаар зүйл.Сонгогчдын нэрийн жагсаалт **үйлдэх, танилцуулах**

18.1.Сонгогчдын нэрийн жагсаалт бол Монгол Улсын иргэний бүртгэлийн салшгүй хэсэг бөгөөд иргэд нийтээрээ сонгох, сонгогдох эрхээ хангах хууль зүйн нэг үндэс мөн.

18.2.Сонгогч нь өөрийн оршин суугаа нутаг дэвсгэрийн сонгуулийн зөвхөн нэг хэсэгт нэг нэрийн жагсаалтад бүртгүүлэн сонгогчийн үнэмлэх авах, хэрэв сонгуулийн хугацаанд түр болон бүрмөсөн шилжвэл уул жагсаалтаас хасуулж, очсон газрынхаа сонгуулийн хэсэгт бүртгүүлэх эрх, үүрэгтэй.

18.3.Өөрийн Тамгын газар ба улсын бүртгэлийн албыг татан оролцуулж тус тусын нутаг дэвсгэрийн хэмжээнд сонгогчдын нэрийн жагсаалтыг хуулийн хугацаанд үнэн зөв, давхардал, хийдэлгүй бүрэн гаргаж сонгуулийн хороодод хүргүүлэх нь тухайн баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын үүрэг мөн.

18.4.Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, магадлан хянах техник ажиллагааг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Улсын бүртгэлийн алба, ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

18.5.Улсын бүртгэлийн алба, ажилтан нь нэрийн жагсаалтыг үйлдэхдээ дараахь журмыг баримтлан биелүүлэх үүрэгтэй:

18.5.1.сум, дүүргийн улсын бүртгэл хариуцсан ажилтан Сонгуулийн ерөнхий хорооны баталсан маягтын дагуу баг, хорооны хүн амын хаягийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг үндэслэн сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Улсын бүртгэлийн албанд хүргүүлэх;

18.5.2.аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх улсын бүртгэлийн алба нь өөрт ирүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг зохих хууль, заавар, маягтын дагуу хянан үзэж аймаг, нийслэлийн хэмжээгээр нэгтгэн 2 хувь үйлдэж Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлэх;

18.5.3.Улсын бүртгэлийн ерөнхий газар хүн амын нэгдсэн бүртгэлийн үндсэн дээр аймаг, нийслэлийн албадаас ирүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг хүн амын бүртгэлтэй тулган шалгаж, үнэн зөвийг тодорхойлон санал авах өдрөөс гурван сарын өмнө Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх.

18.6.Сонгуулийн ерөнхий хороо нь сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрээр гаргасан сонгогчдын нэрийн жагсаалтыг вэб хуудаст байрлуулж, уг жагсаалтыг санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн болон салбар хороогоор дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ.

18.7.Хэсгийн хороо энэ хуулийн 18.6-д заасны дагуу ирүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгаж, санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө нэгтгэн 2 хувь үйлдэж, хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэгтэйгээр санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө хэсгийнхээ санал авах байранд ил тавьж сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно.

18.8.Энэ хуулийн 18.6-д заасан вэб хуудаст байрлуулсан сонгогчдын нэрийн жагсаалттай нам, эвсэл, нэр дэвшигч, түүнчлэн сонгогч танилцах боломжтой байвал зохино.

18.9.Сонгогчдын нэрийн жагсаалтад түүнийг үйлдэх үед тухайн хэсэгт байнга буюу түр оршин суугаа бүх сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, оршин суугаа газрын хаяг, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаарыг бүртгэх бөгөөд ийнхүү бүртгэхдээ сонгогчийн нэрийг оршин суугаа газрын байршлаар нь аль тохиромжтой байдлаар дараалуулан бичнэ.

18.10.Сонгогчдын нэрсийн жагсаалт нь үндсэн ба нэмэлт, зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах жагсаалтаас бүрдэнэ.

18.11.Сонгуулийн хороод нь хэсгийн сонгогчдын тоог Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу гаргахдаа зөвхөн сонгуулийн хэсгийн хороонд байгаа нийтэд танилцуулсан сонгогчдын нэрийн жагсаалтыг баримтлан гаргана.

18.12.Эмнэлэг, амралт, сувиллын газар, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цэргийн анги салбарын захиргаа нь сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэхэд шаардагдах мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

18.13.Иргэний бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сонгуулийн насны иргэдийн нэрийн жагсаалтыг жил тутам гаргаж, цахим хуудсанд байрлуулан иргэнд зөвхөн өөрийн мэдээллийг шалган танилцах боломжоор хангана.

18.14.Тухайн хэсэгт оршин суух бүртгэлтэй боловч санал авах өдөр тодорхой шалтгаанаар гадаад оронд байгаа, түүнчлэн цэргийн алба хааж байгаа, цагдан хоригдож байгаагийн улмаас өөрийн биеэр хүрэлцэн ирж санал өгөх боломжгүй иргэдийг сонгогчдын үндсэн нэрийн жагсаалтад бүртгэхгүй.

18.15.Хэсгийн хорооны гишүүдийн ажлын хэрэгцээнээс бусад зориулалтаар сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж олшруулах, тараахыг хориглоно.

18.16.Энэ хуулийн 18.5-д заасныг зөрчсөн улсын бүртгэлийн ажилтныг 200000-300000 төгрөгөөр, 18.7-д заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг 250000-300000 төгрөгөөр, 18.15-д заасныг зөрчсөн буруутай этгээдийг 250000-300000 төгрөгөөр торгоно.

19 дүгээр зүйл.Хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах

19.1.Хэсгийн хороо энэ хуулийн 18.6-д заасан нэрийн жагсаалтыг хүлээн авснаас хойш түүнийг дараахь журмаар нягтлан шалгана:

19.1.1.нэрийн жагсаалтад байгаа иргэн дурдсан хаягтаа оршин сууж байгаа эсэхийг хаягийн дагуу явж шалгах,

19.1.2.иргэний бүртгэлийн байгууллагын мэдээллийн санд буй тухайн сонгогчийн талаархи мэдээлэлтэй тулган шалгах,

19.1.3.сонгогчийн баримт бичгийн мэдээлэлтэй тулган шалгах.

19.2.Хэсгийн хороо нэрийн жагсаалтыг нягтлан шалгасны дараа түүний дүнг үндэслэн дараахь арга хэмжээг авна:

19.2.1.тухайн хаягт бүртгэлгүй нь тогтоогдсон сонгогчийн нэрийг сонгогчдын нэрийн жагсаалтаас хасах,

19.2.2.сонгогчийн овог, нэр зөрсөн, алдаатай бичигдсэн зэргээр бодит баримт бичгээс зөрсөн зөрчлийг арилгах,

19.2.3.сонгогч нэрийн жагсаалтад ороогүй орхигдсон бол түүний нэрийг сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэн авах,

19.2.4. тухайн иргэний баримт бичгийн зөрчлийг арилгуулахыг шаардах.

19.2.5. гомдлыг хэрэгсэхгүй болгох.

19.3.Хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах ажлыг санал авах өдрөөс ажлын 1 өдрийн өмнө дуусгавар болгох бөгөөд үүнээс хойшхи хугацаанд сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдох гомдлыг хүлээн авахгүй.

20 дугаар зүйл.Сонгогчдын нэрийн жагсаалтын талаар гомдол гаргах

20.1.Сонгогчийг нэрийн жагсаалтад бүртгээгүй буюу буруу бүртгэсэн байвал сонгогч тухайн хэсгийн хороонд гомдол гаргах эрхтэй.

20.2. Хэсгийн хороо гомдлыг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан үзэж, сонгогчдын нэрийн жагсаалтад зохих өөрчлөлтийг тэр даруй оруулах буюу гомдлыг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргаж хариу мэдэгдэнэ.

20.3 Сонгогч энэ хуулийн 20.2-т заасны дагуу гомдлыг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ тухай гомдлоо хоёр хоногийн дотор салбар хороонд, салбар хороогүй бол харьяалагдах аймаг, нийслэлийн хороонд гаргах бөгөөд эдгээрээс гаргасан шийдвэр нь эцсийн байна.

21 дүгээр зүйл.Сонгогч шилжих

21.1.Сонгогч сонгуулийн өөр хэсэгт шилжвэл энэ тухайгаа бичгээр хэсгийн хороонд мэдүүлэн шилжүүлэг хийлгэж, сонгогчдын нэрийн жагсаалтаас хасуулна.

21.2.Шилжсэн сонгогч нь шилжүүлэг хийсэн тэмдэглэл бүхий сонгогчийн үнэмлэх, иргэний үнэмлэхээ хянуулж, очсон газрынхаа хаягаар сонгогчдын нэрийн нэмэлт жагсаалтад бүртгүүлнэ.

21.3.Шилжин ирж, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчийн саналыг тусгай хайрцагт авах ба тусад нь тоолж, дүнг гаргана.

21.4.Сонгуулийн санал авах өдрөөс 30 хоногийн дотор сонгогчийн шилжих хөдөлгөөнөөр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэл, хөдөлгөөн хийхийг хориглоно.

21.5.Сонгогч энэ хуулийн 21.4-т заасан хугацаанд шилжвэл өөрийн харьяалах хэсэгтээ саналаа битүүмжилсэн дугтуйгаар урьдчилан өгөх ба түүнд шилжүүлэг хийхийг хориглоно.

21.6.Энэ хуулийн 21.4-т заасан сонгогчийн саналыг авахдаа мөн хуулийн 21.3-т заасан журмыг баримтална.

21.7.Энэ хуулийн 21.4-21.6-д заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг 200000-250000 төгрөгөөр торгож, сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах бөгөөд түүнийг бүрэлдэхүүнээс хасах асуудлыг дээд шатны сонгуулийн хороо хэлэлцэж шийдвэрлэнэ.

21.8.Энэ хуулийн 21.4, 21.5-д заасан зөрчил гаргасан нь холбогдох этгээдийг 1 жилийн хугацаагаар эргэж орох нөхцөлгүйгээр төрийн албанаас халах үндэслэл болох бөгөөд зохих хороо нь хууль зүйн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

22 дугаар зүйл.Сонгогчийн үнэмлэх, түүнийг олгох

22.1.Хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчид сонгогчийн үнэмлэх олгоно. Сонгогчийн үнэмлэхийн загвар болон сонгогчийн үнэмлэх олгох, түүнд тэмдэглэл хийх журмыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

22.2.Сонгогчийн үнэмлэхэд сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, санал авах байрны хаягийг бичнэ.

22.3.Сонгогчийн үнэмлэх бар кодтой байх бөгөөд түүнд тусгах мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороо батална.

22.4.Сонгогчийн үнэмлэхийг хэсгийн хорооны аль нэг гишүүн олгох бөгөөд үнэмлэхийг хүлээн авсан хүнээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

22.5.Сонгогчийн үнэмлэх тараасан хэсгийн хорооны гишүүний нэрийг сонгогчдын нэрийн жагсаалт дахь сонгогчийн нэрийн ард тэмдэглэнэ.

22.6.Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хаягтаа түр эзгүй байгаа бол тухайн сонгогчийн үнэмлэхийг хэсгийн хороо сонгогчийн үнэмлэх олгох жагсаалтад тэмдэглэж хадгалах бөгөөд сонгогч өөрөө ирсэн тохиолдолд иргэний үнэмлэхтэй нь тулган нягталсаны үндсэн дээр сонгогчийн үнэмлэхийг нь олгоно.

22.7.Энэ хуулийн 22.1, 22.4, 22.5, 22.6-д заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг 250000-300000 төгрөгөөр, гишүүнийг 200000-250000 төгрөгөөр торгож, 22.1-д заасныг зөрчиж нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгогчид сонгогчийн үнэмлэх олгосон этгээдийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах ба түүнийг дахин томилохгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ

Нам, эвсэл сонгуульд оролцох

23 дугаар зүйл. Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх

23.1. Сонгууль зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам нь сонгуульд Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлж оролцох эрхтэй.

23.2. Хоёр буюу хэд хэдэн нам сонгуульд нэгэн эвсэл болон оролцож болох ба энэ тохиолдолд энэ хуулийн 23.1 дэх хэсгийн заалт эвсэлд нэгдэн орж байгаа нам тус бүрд адил хамаарна.

23.3. Нам, эвсэл сонгуульд оролцох хүсэлтээ санал авах өдрөөс 50-иас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр илэрхийлж, албан ёсоор бүртгүүлнэ.

23.4. Нам, эвсэл нь сонгуульд оролцох хүсэлтдээ дараахь баримт бичгийг хавсарган Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ:

23.4.1. нам дангаараа оролцох бол намын Их Хурал, эсхүл намын Их Хурлаас сонгож байгуулсан намын төлөөллийн төв байгууллагын шийдвэр, эвсэл байгуулж оролцох бол энэ хуулийн 24.1.4-т заасан эвслийг төлөөлөх байгууллагын шийдвэр;

23.4.2. намын буюу эвслийн тухайд түүнд нэгдэн орсон намуудын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

23.4.3. нам, эвслийн сонгуулийн батлагдсан мөрийн хөтөлбөр;

23.4.4. өмнөх сонгуулиас хойшхи хугацаанд тухайн намд буюу эвсэлд нэгдэн орсон намуудад иргэд, хуулийн этгээдээс өгсөн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан хандивын тайлан;

23.4.5. нам, эвслийн сонгууль эрхлэх төв байгууллагын нэр, түүний бүрэлдэхүүн, байрлах газрын хаяг, харилцах утасны дугаар зэргийг агуулсан мэдээлэл.

23.5. Эвсэлд нэгдсэн намуудын төлөөлөх байгууллага нь энэ хуулийн 23.4-т зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлж Сонгуулийн ерөнхий хороонд өгнө:

23.5.1. эвслийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

23.5.2. эвсэлд нэгдэн орсон нам тус бүрийн удирдах дээд байгууллагын энэ хуулийн 24.1-д заасан хуралдааны шийдвэр, тэмдэглэл.

24 дүгээр зүйл. Намууд сонгуулийн эвсэл байгуулах, эвслийн гэрээ

24.1. Энэ хуулийн 23.1-д зааснаар Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн намууд Улсын Их Хурлын тухайн ээлжит сонгуульд эвсэл байгуулж оролцох бол түүнд нэгдэн орох нам тус бүр өөрийн Их Хурал, эсхүл төлөөллийн төв байгууллагын хуралдааныг хийж, дараахь асуудлыг шийдвэрлэнэ:

24.1.1.эвслийн нэр, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэлэлцэн батлах;

24.1.2.эвсэлд нэгдэн орох нам тус бүрт ногдох нэр дэвшигчийн тоог тогтоох;

24.1.3.нам тус бүр өөрт ногдсон тоонд багтаан нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;

24.1.4.цаашид сонгуультай холбогдсон асуудлаар эвсэлд тухайн намыг төлөөлөн шийдвэр гаргах эрхтэйгээр оролцох эрх бүхий төлөөлөгчид /цаашид "төлөөлөх байгууллага" гэх/-ийг томилох;

24.1.5.эвслийн гэрээг хэлэлцэж, дэмжих эсэхээ илэрхийлэх.

24.2.Энэ хуулийн 24.1-д заасан байгууллага нь мөн хуулийн 24.1.3-т заасан асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

24.3.Эвсэлд нэгдэн орох намууд тус бүрдээ энэ хуулийн 24.1-д заасан асуудал тус бүрийг шийдвэрлэж, нэгдсэн тохиролцоонд хүрсэн бол эвслийг албан ёсоор байгуулагдсанд тооцох бөгөөд түүнд нэгдэн орсон намуудын дарга нар эвслийн гэрээнд гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулна.

24.4.Эвсэл албан ёсны нэртэй байх бөгөөд түүнийг хувь хүн, улс, үндэстэн, овгийн нэрээр болон урьд нь өөр намуудын эвслийн хэрэглэсэн нэрээр нэрлэхийг тус тус хориглох ба нэгэнт зарлагдсан эвслийн нэрийг сонгуулийн явцад болон шинээр сонгогдсон Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд өөрчлөхийг хориглоно.

24.5.Энэ хуулийн 24.1, 24.3-т заасны дагуу нэгэнт байгуулагдсан эвсэлд сонгуулийн явцад болон шинээр сонгогдсон Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд өөр нам нэгдэж орохыг хориглоно.

24.6.Эвслийг төлөөлөх байгууллага нь эвсэлд нэгдэн орсон нам бүрээс энэ хуулийн 24.1.4-т заасны дагуу томилогдсон төлөөлөгчдөөс бүрдэх бөгөөд эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, гэрээнд өөрчлөлт оруулах, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд зэрэг улс төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг татан гаргах, түүний оронд өөр хүний нэр дэвшүүлэх, эвслийн гэрээг цуцлах зэргээр сонгууль болон эвсэлтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлэх боловч энэ хуулийн 24.1.2-т заасны дагуу намуудад ногдсон суудлын тоог өөрчлөх эрхгүй.

24.7.Эвслийн гэрээнд талуудын нийтлэг болон харилцан хүлээх эрх, үүрэг, эвслийн нэр, эвслийг төлөөлөх байгууллага, түүний удирдах бүрэлдэхүүнд орсон иргэний эцэг /эх/-ийн нэр, нэр, албан тушаал, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүнийг төлөөлөх албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр болон харилцан тохиролцсон бусад асуудлыг тусгана.

24.8.Эвслийн гэрээ нь тухайн сонгууль, түүний үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

24.9.Эвсэлд нэгдэн орсон намууд нь Улсын Их Хурлын ээлжит сонгууль, түүнчлэн шинээр сонгогдсон Улсын Их Хуралд нэгэн этгээд болж оролцох бөгөөд эвслийн аль нэг нам дангаараа /эвслээс гадуур/ нэр дэвшүүлэх, сонгуулийн зардлын данс нээлгэх, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан сонгуульд орохыг хориглох бөгөөд хэрэв аль нэг нам нь ийм шийдвэр гаргасан бол эвслийг тарсан гэж үзнэ.

24.10.Эвсэлд нэгдэн орсон нам хэдийд ч эвслээс гарах эрхтэй бөгөөд түүний энэ хуулийн 24.1-д заасан байгууллага нь мөн хуулийн 24.6-д заасан төлөөлөх байгууллагад энэ тухай албан ёсоор мэдэгдсэнээр тухайн намыг эвслээс гарсанд тооцох бөгөөд энэ тохиолдолд эвслийг бүхэлд нь тарсан гэж үзнэ.

24.11.Энэ хуулийн 24.1.4-т заасан төлөөлөх байгууллага эвслийн гэрээг хэдийд ч цуцалж болно.

24.12.Энэ хуулийн 24.9-24.11-д заасны дагуу эвсэл нэгэнт тарсан бол Улсын Их Хурлын тухайн сонгуулийн явцад болон түүний үр дүнд байгуулагдсан Улсын Их Хуралд эвслийн бүрэлдэхүүнд орж байсан намууд дахин нэгдэж эвсэл байгуулах, түүнчлэн Улсын Их Хуралд нэг бүлэг болон зохион байгуулагдахыг хориглоно.

25 дугаар зүйл. Сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх

25.1.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу сонгуульд оролцохоо илэрхийлсэн нам, эвслийг бүртгэхдээ тэдгээрийн ирүүлсэн баримт бичиг үнэн зөв, гүйцэд эсэхийг нягтлан шалгана.

25.2.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 23.4, 23.5-д заасан баримт бичгийг үндэслэн тэдгээрийг хүлээн авснаас хойш тав хоногт багтаан сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана.

25.3.Дараахь тохиолдолд нам, эвслийг бүртгэхээс татгалзана:

25.3.1.нам буюу эвсэлд нэгдэн орсон намуудын аль нэг нь энэ хуулийн 23.1-д заасан шаардлага хангаагүй бол;

25.3.2.энэ хуулийн 23.4, 23.5-д заасан баримт бичиг дутуу, эсхүл хуурамч бол;

25.3.3.энэ хуулийн 23.4, 23.5-д заасан аль нэгэн баримт бичгийг мөн хуулийн 23.3-т заасан хугацаа дууссанаас хойш ирүүлсэн бол;

25.3.4.эвсэл байгуулах тухай шийдвэр гаргахдаа энэ хуулийн 24.1.1-24.1.4-т заасан журам, шаардлагыг зөрчсөн бол;

25.3.5.эвсэлд нэгдэн орсон аль нэг нам нь бүртгэсэн тухай шийдвэр гарахаас өмнө энэ хуульд заасны дагуу эвслээс гарахаа илэрхийлсэн бол;

25.3.6.өмнөх ээлжит сонгуулийн зардлын тайланг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол.

25.4.Сонгуулийн ерөнхий хороо нам, эвслийг бүртгэсэн тухай шийдвэр гаргасан бол батламж олгоно.

25.5.Энэ хуулийн 25.4-т заасны дагуу эвсэл сонгуульд оролцохоор бүртгүүлснээс хойш түүнд аль нэг нам, эвсэл нэгдэн орохыг хориглоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ **Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх,** **нэр дэвшигчийг бүртгэх**

26 дугаар зүйл.Нэр дэвшүүлэх нийтлэг журам

26.1.Сонгуульд оролцох нам, эвсэл Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг сонгууль зарласнаас хойш 20 хоногийн дараа эхлүүлж, 7 хоногийн хугацаанд дуусгана.

26.2.Сонгуульд бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааг сонгууль зарласнаас хойш 15 хоногийн дараа эхлүүлж, 12 хоногийн хугацаанд дуусгана.

26.3.Энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчээр бүртгүүлж, үнэмлэх авсан иргэнийг “Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигч” /цаашид “нэр дэвшигч” гэх/ гэж үзнэ.

26.4.Нэр дэвшигч нь энэ хуулийн 5.6-д зааснаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

26.4.1.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх;

26.4.2.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх;

26.4.3.ял шийтгүүлж байгаагүй, эсхүл ял шийтгүүлж байсан боловч Эрүүгийн хуулийн 78.2, 78.3-т заасны дагуу ялгүй болсон буюу ялгүйд тооцогдсон байх.

26.5.Төрийн жинхэнэ албан хаагч Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших болсон бол энэ хуулийн 29.2-т заасан баримт бичгийг холбогдох сонгуулийн хороонд

хүргүүлэхээс өмнө Төрийн албаны тухай хуульд⁸ заасны дагуу уг албанаас чөлөөлөгдсөн байна.

26.6.Нэг намын гишүүнийг нөгөө намаас, эвслийн тухайд түүнд нэгдэн орсон намуудынхаас өөр намын гишүүнийг нэр дэвшүүлэхийг тус тус хориглоно.

27 дугаар зүйл. Нам, эвслээс нэр дэвшүүлэх

27.1.Нам, эвсэл нь 76-аас илүүгүй хүний нэрийг жагсаалтаар дэвшүүлнэ.

27.2.Нам, эвслээс нэр дэвшигчдийн 15-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд, 2-оос доошгүй нэр дэвшигч нь казах иргэдийн төлөөлөл байна.

27.3.Намаас нэр дэвшүүлэх тухай асуудлыг Улс төрийн намын тухай⁹ хуулийн 13.7-д заасны дагуу тухайн намын Их Хурал, эсхүл төлөөллийн төв байгууллагын хуралдаанаар хэлэлцэж, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

27.4.Нам, эвсэл нь энэ хуулийн 27.3-т заасны дагуу нэр дэвшүүлэх ажиллагааг явуулахдаа дор дурдсан журмыг баримтална:

27.4.1.энэ хуульд заасан шаардлагыг хангасан намын гишүүн ба гишүүн бус хүнийг намын дүрмийг баримтлан анхан шатны намын байгууллагаас эхлэн нэр дэвших, шилж сонгогдох адил тэгш боломж олгох үндсэн дээр шалгаруулах;

27.4.2.энэ хуулийн 27.4.1-д заасны дагуу нэр дэвшүүлэхдээ улс төрийн хуйвалдаан зохион байгуулах, эд мөнгөөр татах, айлган сүрдүүлэх, хууран мэхлэх үйл ажиллагаа явуулахыг хориглох;

27.4.3.энэ хуулийн 27.1-д заасан тоонд багтаан нэр дэвшүүлэн жагсаахдаа санал авсан тоогоор /хувиар/ нь эрэмбэлэн дугаарлан бичих;

27.4.4.нэр дэвшүүлэхдээ тухайн хүн Улсын Их Хурлын гишүүн байх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвартай эсэх, эх орон, ард түмнийхээ тусын тулд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж, Монгол Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалан бэхжүүлэх төгс эрмэлзэлтэй эсэх, шударга ёс, хууль дээдлэх ёс, Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх чадвартай эсэхийг харгалзан үзэх;

27.4.5.нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэсэн хуралдааны шийдвэрт намын Их Хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага, гишүүдийн тоо, хуралдаанд оролцсон гишүүдийн ирц, нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтыг санал авсан хувь, нэр дэвшигч хүн энэ хуульд заасан болзол, шаардлагыг хангасан талаар тусгах.

27.5.Эвслээс нэр дэвшүүлэхэд энэ хуулийн 24.1.2, 24.1.3, 24.2-т заасан журмыг баримтална.

⁸ Төрийн албаны тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

⁹ Улс төрийн намын тухай хууль -“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2005 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

27.6.Нам, эвсэл нэр дэвшүүлэх талаар энэ хуулийн заалтад нийцүүлэн өөрсдийн дотоодод мөрдөх аргачилсан журмыг тогтоон мөрдөж болно.

28 дугаар зүйл. Бие даан нэрээ дэвшүүлэх

28.1.Бие даан нэрээ дэвшүүлэгч нь энэ хуулийн 6.2-т заасан тооны дэмжигч-сонгуулийн эрх бүхий иргэний гарын үсгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу зуруулж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ. Маягтыг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо тэмдэг дарж олгоно.

28.2.Энэ хуулийн 28.1-д заасан маягтад дэмжигч- сонгуулийн эрх бүхий иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийг гаргацтай, тодорхой бичсэн байна.

29 дүгээр зүйл.Нэр дэвшигчийг бүртгэх

29.1.Нэр дэвшигчийг Сонгуулийн ерөнхий хороо бүртгэнэ.

29.2.Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь энэ хуулийн 26.1-д заасан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш тав хоногийн хугацаанд багтаан дараахь баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороо хороонд ирүүлнэ:

29.2.1.нэр дэвшүүлсэн тухай шийдвэр, тэмдэглэл;

29.2.2. нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалт, хүн бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл;

29.2.3.нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг;

29.2.4.энэ хуулийн 26.4.1, 26.4.2-т заасан өр төлбөргүй болох тухай нэр дэвшигчийн мэдүүлэг, эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

29.2.5.энэ хуулийн 26.4.3-т заасныг нотолсон цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

29.2.6.төрийн жинхэнэ албан хаагчийн тухайд ажлаас чөлөөлөгдсөн тухай байгууллагын шийдвэр;

29.2.7.нэр дэвшигчийн намтар.

29.3.Бие даан нэр дэвшигч нь энэ хуулийн 26.2-т заасан хугацаанд багтаан энэ хуулийн 29.2.3-29.2.7-д заасан баримт бичиг болон дэмжигч-сонгуулийн эрх бүхий иргэдийн дэмжлэгийг илэрхийлсэн гарын үсэг бүхий маягт, нэр дэвшүүлснээ илэрхийлсэн мэдэгдлийн хамт Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

29.4.Энэ хуулийн 29.2.4-т заасан өр төлбөрийн тухай тодорхойлолтыг Улсын дээд шүүх, 29.2.5-д заасан тодорхойлолтыг цагдаагийн төв байгууллага нэр дэвшигч тус бүрээр гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд албан бичгээр хүргүүлнэ.

29.5.Энэ хуулийн 29.2.3, 29.2.4, 29.2.7, 29.3-т заасан баримт бичгийн загварыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

29.6.Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийг бүртгэхдээ нам, эвсэл болон нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичиг үнэн зөв, гүйцэд эсэх, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа хуулийн дагуу явагдсан эсэхийг нягтлан шалгана.

29.7.Бие даан нэр дэвшигчийг дэмжсэн сонгуулийн эрх бүхий иргэний гарын үсэг үнэн зөв эсэхийг Сонгуулийн ерөнхий хороо сонгогчийн иргэний үнэмлэх, оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй тулгах буюу шаардлагатай бол тухайн иргэнтэй уулзаж нягтлан шалгах бөгөөд уг ажлыг аймаг, нийслэлийн болон салбар хороогоор гүйцэтгүүлж болно.

29.8. Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 29.2, 29.3-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор нэр дэвшигчээр бүртгэх эсэх тухай асуудлыг шийдвэрлэнэ.

29.9.Дараахь тохиолдолд Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзана:

29.9.1.энэ хуулийн 26.1, 26.2-т заасан хугацаанд нэр дэвшүүлэх ажиллагааг явуулаагүй;

29.9.2.энэ хуулийн 26.4, 26.5-д заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй;

29.9.3.энэ хуулийн 26.6-д заасныг зөрчиж, өөр намын гишүүнийг нэр дэвшүүлсэн;

29.9.4.нэр дэвшүүлэх ажиллагаа энэ хуулийн 27 дугаар зүйлд заасныг зөрчиж явагдсан бол нийт нэр дэвшигчийг;

29.9.5.энэ хуулийн 29.2-т заасан баримт бичиг дутуу, эсхүл хуурамч бол;

29.9.6.бие даан нэр дэвшигч нь энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан журам зөрчсөн, түүнчлэн дэмжигч-сонгуулийн эрх бүхий иргэний гарын үсгийг цуглуулахдаа бусдыг төлөөлүүлэх, хүч хэрэглэх, хуурч мэхлэх, заналхийлэх, эд мөнгөөр татах, сонгуулийн эрхгүй этгээдээр гарын үсэг зуруулах, гарын үсэг хуурамчаар үйлдэх зэрэг хууль бус арга хэрэглэсэн, эсхүл Сонгуулийн ерөнхий хорооноос баталснаас өөр маягтаар гарын үсэг цуглуулсан.

29.10.Энэ хуулийн 29.9-д заасан үндэслэл байхгүй бол Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэр гаргана.

29.11. Сонгуулийн ерөнхий хороо бүртгэгдсэн нэр дэвшигчид нэр дэвшигчийн үнэмлэх олгоно.

29.12.Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ хуулийн 30.4-т заасан хугацааны дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр урьд нь нэр дэвшигчийг

бүртгүүлэх хүсэлтээ дахин уламжлах, эсхүл энэ хуульд заасан журмын дагуу өөр хүний нэрийг дэвшүүлж болно.

29.13. Сонгуулийн ерөнхий хороо ажлын зургаан өдрийн дотор нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалтыг улсын хэмжээнд нэгтгэж, нийтэд мэдээлнэ.

29.14. Энэ хуулийн 29.2, 29.3-т заасан баримт бичгийг хуурамчаар үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол, эсхүл энэ хуулийн 29.9-т заасан үндэслэл нэр дэвшигч бүртгэгдсэний дараа тогтоогдсон бол нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтныг 150000-200000 төгрөгөөр, албан тушаалтныг 250000-300000 төгрөгөөр, нам, эвслийг 5000000-10000000 төгрөгөөр торгож, нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасна.

29.15. Энэ хуулийн 29.9-т заасан зөрчил байгааг мэдсэн атлаа нэр дэвшигчийг бүртгэсэн бол сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг 250000-300000 төгрөгөөр, гишүүнийг 200000-250000 төгрөгөөр торгож, буруутай этгээдийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасна.

30 дугаар зүйл. Нэр дэвшигч татгалзах, нэр дэвшигчийг татан гаргах

30.1. Энэ хуулийн 29.10, 29.11-д заасны дагуу бүртгэгдэж, үнэмлэх авсан бие даан нэр дэвшигч өөрөө татгалзах, эсхүл нам, эвсэл нь өөрийн нэр дэвшигчийг татан гаргах, түүний оронд өөр хүний нэрийг дэвшүүлэх эрхтэй.

30.2. Бие даан нэр дэвшигч өөрөө татгалзах буюу нам, эвсэл нь өөрийн нэр дэвшигчээ татан гаргах тухай шийдвэрээ Сонгуулийн ерөнхий хороонд нэн даруй хүргүүлнэ.

30.3. Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 30.2-т заасан шийдвэрийг хүлээн авмагц тухайн нэр дэвшигчийг бүртгэсэн шийдвэрээ хүчингүйд тооцсон тухай шийдвэр гаргаж, энэ тухай нийтэд мэдээлнэ.

30.4. Нам, эвсэл нь өөрийн нэр дэвшигчээ татан гаргасан шийдвэрээ санал авах өдрөөс 18 хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол татгалзсан болон татан гаргасан нэр дэвшигчийн оронд өөр хүний нэрийг дэвшүүлэх эрхгүй.

30.5. Саналын хуудас хэвлэгдсэний дараа бие даан нэр дэвшигч өөрөө татгалзах, эсхүл нам, эвсэл нь өөрийн нэр дэвшигчээ татан гаргах эрхгүй болно.

31 дүгээр зүйл. Нөхөн нэр дэвшүүлэх

31.1. Энэ хуулийн 30.4-т заасан хугацаанд нам, эвсэл нь өөрийн нэр дэвшигчээ татан гаргасан, нам, эвслээс нэр дэвшигч нас барсан, хүндээр өвчилсөн, гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан, захиргааны журмаар баривчлагдсан, шүүхээр ял шийтгүүлсэн тохиолдолд тухайн нам, эвсэл өөр хүний нэрийг нөхөн дэвшүүлж энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан журмын дагуу бүртгүүлж болно.

32 дугаар зүйл.Нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах

32.1.Нэр дэвшигч энэ хуулийн 29.10, 29.11-д заасны дагуу бүртгүүлж, 29.13-д заасны дагуу нийтэд зарлагдсаны дараа түүнийг нэр дэвшигчийн жагсаалтаас хасах талаархи энэ хуульд заасан үндэслэл тогтоогдвол Сонгуулийн ерөнхий хороо энэ тухай шийдвэр гаргаж, нийтэд мэдээлнэ.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасан Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийн талаар маргаан гарвал энэ хуулийн 11 дүгээр бүлэгт заасан харьяалал, журмын дагуу шийдвэрлэнэ.

33 дугаар зүйл. Нэр дэвшигчид туслах

33.1.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс сонгогчидтойгоо уулзах, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сурталчлах зэргээр сонгуульд оролцох бүхий л ажилд нь тухайн нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, ухуулагч, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч тус тус тусална.

33.2.Аймаг, нийслэлийн хороо 500 сонгогчид нэгээс илүүгүй байхаар тооцож, бие даан нэр дэвшигчийн шадар туслагчийг бүртгэж, үнэмлэх олгоно.

33.3.Нэг нам, эвслийн жагсаалтаар нэр дэвшигчдийн сонгуулийн өмнөх ухуулгыг тухайн нам, эвсэл нийт нэр дэвшигчдийнхээ өмнөөс бүхэлд нь эрхлэн явуулах ба үүний тулд аймаг, нийслэл бүрт ухуулгын баг байгуулж Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлэн үнэмлэх авч ажиллуулна.

33.4.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, ухуулагч, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч нь сонгуулийн аль нэг хорооны гишүүн байхыг хориглоно.

34 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаа

34.1.Нам, эвсэл болон нэр дэвшигч нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сурталчилгаа хийх, холбогдох байгууллагаас зохих журмын дагуу шаардлагатай мэдээлэл, лавлагаа авах эрх эдэлнэ.

34.2.Гэмт үйлдлийнх нь явцад хойшлуулшгүй баривчлахаас бусад тохиолдолд нэр дэвшигчийг Сонгуулийн ерөнхий хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл ногдуулах, орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийх, түүнчлэн захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглоно.

34.3.Нэр дэвшигчийг гүтгэх, доромжлох, нэр төрийг нь гутаах, түүний хувийн болон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

34.4.Энэ хуулийн 34.1-д заасан эрхээ хэрэгжүүлэхэд санаатайгаар саад учруулсан иргэнийг 150000-200000 төгрөгөөр, албан тушаалтныг 250000-300000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 5000000-10000000 төгрөгөөр торгоно.

34.5.Энэ хуулийн 34.2-т заасныг зөрчсөн төрийн албан хаагчид Цагдаагийн байгууллагын тухай, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах ба бусад албан тушаалтныг 250000-300000 төгрөгөөр торгоно.

34.6.Энэ хуулийн 34.3-т заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал иргэнийг 150000-200000 төгрөгөөр, албан тушаалтныг 250000-300000 төгрөгөөр, нам, эвслийг 5000000-10000000 төгрөгөөр, хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагыг 5000000-10000000 төгрөгөөр торгоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгаа

35 дугаар зүйл.Сонгуулийн мөрийн хөтөлбөр

35.1.Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна. Сонгуулийн мөрийн хөтөлбөрт мөнгөн дүнгээр илэрхийлсэн амлалт авахыг хориглоно.

35.2.Улсын Их Хурлын тухайн сонгуульд олонхи суудал авсан нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндэс болно.

35.3.Нам, эвслээс нэр дэвшигч нь тухайн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс өөр бие даасан мөрийн хөтөлбөртэй байхыг хориглоно.

35.4.Нам эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаархи тооцоо, судалгааг хөндлөнгийн хяналтын байгууллагаар хийлгэсэн байна.

35.5.Энэ хуулийн 35.3-т заасныг зөрчсөн нэр дэвшигчийг 150000-200000 төгрөгөөр, нам, эвслийг 5000000-10000000 төгрөгөөр торгож, нэр дэвшигчийг намын нэрийн жагсаалтаас хасна.

36 дугаар зүйл.Сонгуулийн сурталчилгаа

36.1.Сонгуулийн сурталчилгааг нам, эвсэл, бие даан нэр дэвшигч энэ хуулийн 29.10, 29.11-д заасны дагуу бүртгүүлж, үнэмлэх авсан өдрөөс эхлүүлнэ.

36.2.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөр, үзэл баримтлалаа тайлбарлан таниулах, нэр дэвшигчийг дэмжин сурталчлах ажлыг уулзалт, хурал, цуглаан хийх, ухуулах байр ажиллуулах зэрэг хуулиар хориглоогүй арга, хэлбэрээр зохион байгуулах эрхтэй.

36.3. Сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00 цагаас өмнө зогсооно.

36.4. Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл нь мөрийн хөтөлбөрөө танилцуулсан хорин хэвлэлийн хуудас бүхий сонин, хэвлэл, арван хэвлэлийн хуудас бүхий нэг ухуулах болон зурагт хуудас, нэр дэвшигчийн намтар, бусад сурталчилгааны материалыг арван хэвлэлийн хуудаст тус тус багтаана.

36.5. Сонгуульд оролцож байгаа бие даан нэр дэвшигч нь мөрийн хөтөлбөрөө танилцуулсан хоёр хэвлэлийн хуудас бүхий хоёр сонин, хэвлэл, нэг хэвлэлийн хуудас бүхий нэг ухуулах болон зурагт хуудас, нэр дэвшигчийн намтар, бусад сурталчилгааны материалыг нэг хэвлэлийн хуудаст тус тус багтаана.

36.6. Энэ хуулийн 36.4, 36.5-д заасан хязгаарлалтын дүнг хэвлэмэл байдлаар сонгогчдод тараах бүх төрлийн хэвлэлийн нийлбэрээр тооцно.

36.7. Сурталчилгааны уриалга, ухуулах болон зурагт хуудас, зарлал зэргийг гудамж, талбай болон олон нийтийн газарт байрлуулах байршлыг сонгуулийн жилийн дөрөвдүгээр сарын нэгний дотор тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

36.8. Олон нийтийн радио, телевиз нь төлбөртэйгээр сонгуулийн аливаа сурталчилгаа явуулахгүй бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон хуваарийн дагуу төлбөргүй сурталчилгаа явуулна.

36.9. Сонгуулийн ерөнхий хороо нь олон нийтийн радио, телевизээр төлбөргүй явуулах сурталчилгааны хуваарийг батлахдаа нам, эвсэл бие даан нэр дэвшигч бүрт тэнцүү хугацаа ногдохоор тооцож, холбогдох шийдвэрийг гаргана.

36.10. Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг төлбөртэй явуулах бөгөөд төлбөртэй сурталчилгааны нийт хугацаа тухайн радио, телевизийн нэвтрүүлгийн нийт хугацааны 10 хувиас хэтрэхгүй байна.

36.11. Энэ хуулийн 36.10-д заасан радио, телевиз нь сонгуулийн сурталчилгааг явуулахдаа энэ хуулийн 36.9-д заасан зарчмыг удирдлага болгоно.

36.12. Нам, эвсэл, тэдгээрийн дэмжигч, бие даан нэр дэвшигч болон нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, ухуулагч, бие даан нэр дэвшигчийн шадар туслагчаас сонгуулийн сурталчилгааны явцад дараахь үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно;

36.12.1. сонгууль зарласнаас хойш нэр дэвшигчийг бүртгэж, үнэмлэх олгох хүртэлх хугацаанд сонгуулийн аливаа хэлбэрийн сурталчилгаа явуулах;

36.12.2. энэ хуулийн 36.3-т заасан хугацаанаас хойш санал хурааж дуустал аливаа хэлбэрээр сурталчилгаа хийх, түүнчлэн санал авах өдөр хүртэлх долоо хоногийн хугацаанд санал асуулга явуулах, дүнг хэвлэн нийтлэх, тараах;

36.12.3.нам, эвслээс нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах;

36.12.4.төрийн болон бусад өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын чанартай ажил, үйлчилгээ явуулах;

36.12.5.энэ хуулийн 36.4, 36.5-д зааснаас илүү материал тараах;

36.12.6. сурталчилгааны уриалга, ухуулах болон зурагт хуудас, зарлалыг барилгын хана, орц, хашаа, гэрлийн шон зэрэг энэ хуулийн 36.7-д зааснаас өөр газарт байрлуулах;

36.12.7.энэ хуулийн 36.8-36.11-т заасныг зөрчиж сурталчилгаа явуулах;

36.12.8.оройн 23 цагаас өглөөний 10 цаг хүртэлх хугацаанд чанга яригч ашиглах;

36.12.9.сонгуульд оролцохоос татгалзах, сонгуулийн болон бусад хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах;

36.12.10.шашны зан үйл ашиглах;

36.12.11.сонгогч, түүний гэр бүл, насанд хүрээгүй хүүхэд, байгууллага, хамт олонд техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, мөнгө, эм тариа, хүнсний болон бусад эд бараа төлбөргүй тараах, хөнгөлөлттэй үнээр худалдах;

36.12.12.төлбөргүйгээр буюу хөнгөлөлттэй үнээр ахуйн болон эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн үзлэг явуулах;

36.12.13.биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, төлбөрт таавар, бооцоот болон мөрийтэй тоглоом зохион байгуулах;

36.12.14.сонгогчдын саналыг татах зорилгоор хүлээн авалт, дайллага, цайллага, сонгуулийн бус олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах;

36.12.15.төрийн байгууллага, түүнчлэн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг төлбөртэй буюу төлбөргүйгээр сурталчилгааны материал хэвлэх, олшруулах, тээвэрлэх зэргээр сурталчилгаанд аливаа хэлбэрээр ашиглах;

36.12.16.төрийн жинхэнэ албан хаагчийг сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр татан оролцуулах;

36.12.17.сонгогчдын санал худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах.

36.13.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, ухуулагч, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч нь сонгуулийн сурталчилгаандаа аливаа шашны сургаал, жаяг дэгийн дагуу үйлддэг

хурал хуруулах, сан тавиулах, майдар эргэх, жасаа уншуулах, даллага авахуулах, тахилга мөргөл үйлдүүлэх, овоо тахих үйлдэл, үйл ажиллагааг зохион байгуулсан, түүнд оролцсон, ийм арга хэмжээг санхүүжүүлсэн, шашны эд өглөгийн зүйл, хэрэгсэл тараасан бол шашны зан үйл ашигласан гэж үзнэ.

36.14.Нам, эвсэл, нэр дэвшигч өөрийн мөрийн хөтөлбөрт тусгасан иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөө, төр, сүм хийдийн харилцаа, шашны талаархи бодлого, үзэл баримтлалыг сонгогчдод тайлбарлан таниулах үйл ажиллагааг энэ хуулийн 36.13-т заасан үйлдэл гэж үзэхгүй.

36.15.Дараахь газруудад сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглоно:

- 36.15.1.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;
- 36.15.2.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж;
- 36.15.3.хүмүүнлэгийн, буяны болон шашны байгууллага;
- 36.15.4.сонгуулийн хороод.

36.16.Энэ хуулийн 36.15.1, 36.15.2 нь мөн хуулийн 37.3-т үл хамаарна.

36.17.Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн сурталчилгааны тэнцвэрт байдалд олон нийтийн оролцоотойгоор хяналт тавьж, энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэнэ.

36.18. Энэ хуулийн 36.1, 36.3, 36.8, 36.10, 36.11-т заасныг зөрчсөн хэвлэл мэдээллийн байгууллагыг 5000000-10000000 төгрөгөөр торгоно.

36.19.Энэ хуулийн 36.12.1-д заасныг зөрчсөн иргэнийг 150000-200000 төгрөгөөр, албан тушаалтныг 200000-250000 төгрөгөөр, нам, эвслийг 5000000-10000000 төгрөгөөр, бусад байгууллагыг 5000000-10000000 төгрөгөөр, 36.12.2-36.12.17, 36.13-т заасныг зөрчсөн ухуулагч, шадар туслагч, дэмжигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтныг 200000-250000 төгрөгөөр, албан тушаалтныг 250000-300000 төгрөгөөр, нам, эвсэл, бусад байгууллагыг 5000000-10000000 төгрөгөөр, 36.12.3-36.12.10, 36.12.15-36.12.17-д заасныг зөрчсөн нэр дэвшигчийг 200000-250000 төгрөгөөр, 36.12.14-т заасныг зөрчсөн нам, эвслийг 5000000-10000000 төгрөгөөр торгох ба энэ хуулийн 36.12.2, 36.12.11-36.12.13-т заасан зөрчил гаргасан нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасна.

37 дугаар зүйл. Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх

37.1.Нам эвсэл, бие даан нэр дэвшигч сонгогчидтой хийх уулзалт, хурал цуглааныг энэ хуулийн 36.1, 36.3-т заасан хугацааны дотор хийнэ.

37.2.тухайн шатны засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга нь нам эвсэл, бие даан нэр дэвшигчид уулзалт, хурал цуглаан зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлж, тэгш хандах үүрэгтэй.

37.3.төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нь энэ хуулийн 37.1-д заасан арга хэмжээнд зориулж соёлын төв, биеийн тамирын болон хурлын танхим, өрөө тасалгааг төлбөргүйгээр ашиглуулна.

37.4. Энэ хуулийн 37.1-д заасныг зөрчсөн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийг 200000-250000 төгрөгөөр, 37.2-т заасныг зөрчсөн Засаг даргыг 250000-300000 төгрөгөөр торгоно.

НАЙМДУГААР БҮЛЭГ **Сонгуулийн зардал**

38 дугаар зүйл.Сонгуулийн зардал

38.1.Нэг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний дотор тогтооно.

38.2.Нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг тухайн нам, эвсэл болон нэр дэвшигч, бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлаа өөрөө тус тус хариуцна.

39 дүгээр зүйл.Сонгуулийн зардлын данс

39.1.Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь өөрийн сонгуулийн зардлын дансыг банкинд нээлгэн, Сонгуулийн ерөнхий хороонд энэ тухай албан ёсоор мэдэгдэж, нийтэд зарлана.

39.2.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь энэ хуулийн 39.1-д зааснаас өөр данс нээлгэхийг хориглоно.

39.3.Энэ хуулийн 39.1-д заасан дансанд нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, дэмжигч байгууллага, иргэдээс оруулсан хандивыг төвлөрүүлж, мөн дансаар дамжуулан зориулалтаар нь зарцуулна.

39.4.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч сонгуульд оролцохоо илэрхийлж, Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлснээс хойш гурав хоногийн дотор энэ хуулийн 39.1-д заасан сонгуулийн дансыг нээлгэсэн байна.

39.5.Энэ хуулийн 39.1-д заасан дансанд төвлөрсөн хөрөнгийг нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах, нэр дэвшигчийг сурталчлах, сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, ухуулагч, шадар туслагчийн бичиг хэрэг, шуудан, холбоо, унааны болон албан томилолт, хөлс, урамшуулал зэрэг зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

39.6.Энэ хуулийн 39.2, 39.3, 39.5-д заасныг зөрчсөн нам, эвслийг 5000000-10000000 төгрөгөөр торгох, 39.3, 39.5-д заасан зөрчил гаргасан нэр дэвшигчийг

нэрийн жагсаалтаас хасах ба 39.1-д заасан данснаас гадуур өгсөн, 39.2-т заасныг зөрчиж нээлгэсэн дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг хурааж, улсын орлого болгоно.

40 дүгээр зүйл. Сонгуулийн хандив

40.1. Нам, эвсэл, нэр дэвшигчид өгөх хандивын дээд хэмжээ хувь хүнээс нэг сая төгрөг, хуулийн этгээдээс гурван сая төгрөг байна.

40.2. Энэ хуулийн 40.1-д заасан хандивын хэмжээг мөн хуулийн 39.1-д заасан дансанд төвлөрүүлсэн хөрөнгийн нийлбэрээр тооцно.

40.3. Хуулийн этгээдээс хандив өгөх тухай шийдвэрийг түүний эрх барих байгууллага гаргана.

40.4. Мөнгөн хандивыг зөвхөн энэ хуулийн 39.1-д заасан дансаар дамжуулж өгнө.

40.5. Хандивыг мөнгөн бус хэлбэрээр өгвөл түүнийг мөнгөн хэлбэрт шилжүүлэн үнэлж, энэ хуулийн 40.1-д заасан хандивын дүнд оруулан тооцно.

40.6. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь сонгуулийн хандивын хэмжээ, хэлбэрийг сонгуулийн зардлын тайланд тусгана.

40.7. Дараахь этгээдээс хандив авахыг хориглоно:

40.7.1. гадаад улс буюу гадаадын байгууллага /хамтарсан байгууллагын гадаадын оролцогч/;

40.7.2. олон улсын байгууллага;

40.7.3. төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

40.7.4. гадаад улсын иргэн;

40.7.5. харьяалалгүй хүн;

40.7.6. сонгууль зарласан өдөр 18 насанд хүрээгүй Монгол Улсын иргэн;

40.7.7. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;

40.7.8. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын өр төлбөртэй, дампуурсан, банкны хугацаа хэтэрсэн зээлийн өртэй хуулийн этгээд;

40.7.9. Үйлдвэрчний эвлэл, шашны болон бусад төрийн бус байгууллага.

40.7.10. байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд.

40.8. Сонгууль бэлтгэн явуулах хугацаанд гадаад, дотоодын тусламжийн эд хөрөнгийг иргэдэд тараах, борлуулж сонгуульд зарцуулахыг хориглоно.

40.9. Энэ хуулийн 40.1, 40.3-40.8-д заасныг зөрчсөн хандивлагч, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтныг 200000-300000 төгрөгөөр, албан тушаалтныг 250000-300000 төгрөгөөр, нам, эвслийг 5000000-10000000

төгрөгөөр торгох, 40.7-д заасан этгээдээс хандив авч зарцуулсан нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах ба 40.1-д заасан хэмжээнээс илүү гарсан, түүнчлэн 39.1-д заасан данснаас гадуур өгсөн болон 40.7-д заасан этгээдээс авсан хандивыг хурааж, улсын орлого болгоно.

41 дүгээр зүйл. Сонгуулийн зардлын тайлан гаргах

41.1. Сонгуулийн зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, түүнийг зарцуулах тухай тайлангийн загвар болон данс нээх, хаах, бүртгэл, тайланг хөтлөх журмыг Сонгуулийн ерөнхий хороо Монголбанкттай хамтран батална.

41.2. Нам, эвслээс нэр дэвшигч нь сонгуулийн санал хураалт дууссанаас хойш 15 хоногт багтаан өөрийн сонгуулийн зардлын тайлангаа нам, эвсэлдээ гаргаж өгөх бөгөөд нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайланг санал хурааж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

41.3. Нам, эвсэл энэ хуулийн 41.2-т заасан сонгуулийн зардлын тайлан /цаашид “зардлын тайлан” гэх/-даа аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна.

41.4. Зардлын тайланг дараахь үзүүлэлтээр гаргана:

41.4.1. санд төвлөрүүлсэн орлогын хэмжээ;

41.4.2. орлогын эх үүсвэр;

41.4.3. хандивлагч иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийнх нь нэр, оршин суугаа газрын хаяг, банкны гүйлгээ хийсэн баримт, хандивын хэмжээ, хэлбэр;

41.4.4. хандивлагч хуулийн этгээдийн нэр, оршин байгаа газрын хаяг, гүйцэтгэх захирлын эцэг /эх/-ийн нэр, өөрийнх нь нэр, хандивын хэмжээ, хэлбэр;

41.4.5. зарлагын задаргаа, гүйцэтгэл;

41.4.6. үлдэгдлийн хэмжээ, байршил.

41.5. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал нь уг дансны бүх хөдөлгөөнийг нэгтгэсэн тайлан гаргаж, энэ хуулийн 41.2-т заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

41.6. Санал хураалт явагдсан өдрөөс хойш зардлын тайланг гаргах хүртэлх хугацаанд энэ хуулийн 39.1-д заасан дансанд аливаа хөдөлгөөн хийхийг хориглоно.

41.7. Сонгуулийн ерөнхий хороо зардлын тайланг хянан үзэж, санал хурааж дууссан өдрөөс хойш 45 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлэх ба хоёр зуун мянга, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, таван зуун мянга, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлана.

41.8. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилтийг төрийн аудитын байгууллага хянан шалгана.

41.9.Энэ хуулийн 41.2-41.6-д заасныг зөрчсөн нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтныг 200000-300000 төгрөгөөр, банкны захирлыг 250000-300000 төгрөгөөр, нам, эвсэл, банкыг 5000000-10000000 төгрөгөөр торгох ба 41.6-д заасан хугацаанд хийсэн гүйлгээтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг банкны өөрийнх нь хөрөнгөөс гаргуулж, улсын орлого болгоно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Санал авах, сонгуулийн дүн гаргах, Улсын Их Хурлын гишүүнийг бүртгэх

42 дугаар зүйл.Санал авах газар, хугацаа

42.1.Сонгогчдын саналыг санал авах өдөр 07 цагаас 20 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна.

42.2.Сонгогчдын санал авах өдөр, цаг, байрыг хэсгийн хороо уул өдөр хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ.

42.3.Сонгогчдоос саналаа нууцаар өгөхөд шаардагдах тооны бүхээг, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг болон санал тоолох төхөөрөмж бүхий байрыг санал авах өдрөөс долоо хоногийн өмнө тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга хариуцаж бэлтгүүлнэ.

42.4.Сонгуулийн хэсгийн хорооны болон санал авах байрыг бэлтгэх заавар, санал бэлтгэх бүхээгийн хэмжээ, загварыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

42.5.Санал авах байранд нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, ухуулагч, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч байрлахыг хориглоно.

42.6.Сонгуулийн хэсэгт саналын хуудас хүлээн авснаас хойш санал авах байрыг цагдаагийн хамгаалалтанд авна.

42.7.Энэ хуулийн 42.3-т заасныг зөрчсөн Засаг дарга, 42.5-д заасныг зөрчсөн ухуулагч, шадар туслагч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтныг 250000-300000 төгрөгөөр, нам, эвслийг 5000000-10000000 төгрөгөөр торгоно.

43 дугаар зүйл.Саналын хуудас

43.1.Саналын хуудас нь сонгогчоос саналаа нууцаар тэмдэглэн илэрхийлэх, сонгуулийн дүнг тоолж гаргах хууль зүйн үндсэн баримт бичиг мөн.

43.2.Саналын хуудасны загвар, тоо, түүнийг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журмыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

43.3.Саналын хуудас нь тусгай нууцлалтай, нэгдсэн таних нууц тэмдэг /бар код/-тэй байна.

43.4.Саналын хуудсыг Сонгуулийн ерөнхий хороо эрхлэн хэвлүүлж, аймаг, нийслэлийн хороонд, тэдгээр нь салбар хороогоор дамжуулан санал авах өдрөөс тав хоногийн өмнө хэсгийн хороонд тус тус албан ёсоор хүлээлгэн өгнө.

43.5.Саналын хуудсанд сонгуульд оролцож байгаа нам, эвслийн нэрийг тухайн нам, эвслээс нэр дэвшигчдийн болон бие даан нэр дэвшигчийн өөрийн нь нэр болон эцэг /эх/-ийн нэрийн хамт бичнэ.

43.6.Саналын хуудсанд намын нэрийг бичихдээ Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн огноог баримталж, хамгийн анх бүртгүүлсэн намыг эхэнд нь бичих замаар дараалалд оруулна.

43.7.Эвслийг энэ хуулийн 43.6-д заасан дараалалд оруулахдаа эвслийн бүрэлдэхүүнд орсон намуудаас хамгийн түрүүнд Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн намын бүртгэлийн огноог баримтална.

43.8.Бие даан нэр дэвшигчийн нэрийг нам, эвслээс нэр дэвшигчийн нэрийн дараа, Сонгуулийн ерөнхий хороонд нэр дэвшсэнээ бүртгүүлсэн дарааллаар саналын хуудсанд бичнэ.

43.9.Саналын хуудсанд тухайн хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй саналын хуудсаар санал авах, өгөхийг хориглоно.

43.10.Сонгуулийн хороод саналын хуудсыг бүрэлдэхүүнээрээ хүлээн авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж, байлцсан бүх гишүүн гарын үсэг зурна.

43.11.Сонгуулийн хорооны аль нэг гишүүн энэ хуулийн 43.10-т заасан тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзвал шалтгаан, үндэслэлээ бичгээр үйлдэж, холбогдох сонгуулийн хороонд өгнө.

43.12.Энэ хуулийн 43.9, 43.10-т заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг 250000-300000 төгрөгөөр, гишүүнийг 200000-250000 төгрөгөөр торгоно.

44 дүгээр зүйл.Санал авах ажиллагаа

44.1.Санал авах өдрийн 07 цагт хэсгийн хорооны бүрэлдэхүүн сонгогчдын төлөөллийг байлцуулан санал тоолох төхөөрөмж, санал авах бүх хайрцгийг нээж харуулан, шалган битүүмжилж, лацдсаны дараа хэсгийн хорооны дарга дараахь мэдээлэл хийнэ:

44.1.1.нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо;

44.1.2.хүлээн авсан, урьдчилан санал авахад зарцуулсан, алдагдаж үрэгдсэн, утсан, үлдсэн саналын хуудасны тоо;

44.1.3.урьдчилан санал өгсөн сонгогчдын тоо, түүний явцад буруу тэмдэглэл хийснээс хүчингүй болсон саналын хуудасны тоо;

44.1.4. зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийн тоо, түүгээр санал өгөх сонгогчийн тоо, санал авах хуваарь;

44.1.5. хүлээн авсан, тараасан, буруу бичсэнээс хүчингүй болсон, алдагдаж үрэгдсэн, устсан, үлдсэн, сонгогчийн үнэмлэхийн тоо.

44.2. Урьдчилан өгсөн саналын тоог тусгайлан тэмдэглэнэ.

44.3. Энэ хуулийн 44.1, 44.2-т заасан ажиллагаа, мэдээллийг нэг бүрчлэн тусгасан тэмдэглэл хөтлөж хэсгийн хорооны бүх гишүүн гарын үсэг зурна.

44.4. Хэсгийн хороо энэ хуулийн 44.1-44.3-т заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа санал хураалтыг эхлүүлэх ба ингэхдээ сонгогчийн үнэмлэх, иргэний үнэмлэхийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэж, сонгогч бүрт саналын хуудас олгоно.

44.5. Саналын хуудас авсан сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсгээ зурж баталгаажуулна.

44.6. Саналаа өгсөн сонгогчийн иргэний үнэмлэх болон сонгогчийн үнэмлэхэд тусгайлан үүрэг хүлээсэн хэсгийн хорооны гишүүн тэмдэглэл хийж, хэсгийн хорооны тэмдэг дарах бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон тусгай тэмдэглэл хэрэглэж болно.

44.7. Санал авах ажиллагаанд нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн томилсон ажиглагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно.

44.8. Санал авах байранд нэр дэвшигч болон зөвшөөрөлгүй бусад этгээд байхыг хориглох бөгөөд энэ нь тэдгээрээс саналаа өгөхөд хамаарахгүй.

44.9. Сонгогчийн саналыг урьдчилан битүүмжлэн авах, зөөврийн битүүмжилсэн хайрцгаар сонгогчийн саналыг авах журмыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

44.10. Энэ хуулийн 44.1-44.6-д заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг 250000-300000 төгрөгөөр, гишүүнийг 200000-250000 төгрөгөөр, 44.8-д заасныг зөрчсөн иргэнийг 150000-200000 төгрөгөөр, албан тушаалтныг 200000-300000 төгрөгөөр торгоно.

45 дугаар зүйл. Сонгуулийн ажиглагч

45.1. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч өөрийн ажиглагчийг томилж ажиллуулна.

45.2. Энэ хуулийн 45.1-д заасан ажиглагч нь санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд бүртгүүлж, ажиглагчийн үнэмлэх авна.

45.3. Энэ хуулийн 45.2-т заасан хугацаа өнгөрсөн бол ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх тухай хүсэлтийг хүлээн авахгүй.

45.4.Ажиглагч нь сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогчийн үнэмлэх бичих, санал авах, тоолох, дүн гаргах үед уг ажлыг сонгуулийн хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглан хянахдаа дараахь эрх эдэлнэ:

45.4.1.сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах;

45.4.2.саналын хуудасны битүүмжлэгдсэн байдалтай танилцах;

45.4.3.санал тоолох ажлыг ажиглах;

45.4.4.бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгуулийн эрх бүхий иргэдээс гарын үсэг цуглуулсан маягттай танилцах;

45.4.5.урьдчилан санал авах үйл ажиллагааг ажиглах;

45.4.6.зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах сонгогчдын нэрийн жагсаалт, тэднээс санал авах чиглэл, хуваарьтай танилцах;

45.4.7.санал өгөх бүхээг, зөөврийн битүүмжилсэн хайрцаг, санал тоолох төхөөрөмж болон санал авах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах;

45.4.8.санал авах байранд сонгуулийн санал авах үйл явцыг бүхэлд нь ажиглаж болохуйц суудалтай байх;

45.4.9.санал авах үйл явцад зөрчил гарвал хэсгийн хорооны даргад мэдэгдэж, залруулахыг хүсэх, илэрсэн зөрчлийн талаар тэмдэглэл хөтлөх, дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан баталгаажуулах, гэрчээр гарын үсэг зуруулах;

45.4.10.хэсгийн хорооны гишүүдээс холбогдох мэдээлэл авах;

45.4.11.ажиглалтын тайлангаа нийтэд тавих, хэвлэн нийтлэх.

45.5.Ажиглагч энэ хуулийн 45.4-т заагаагүй эрх эдлүүлэхийг шаардах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, худал, хуурамч мэдээлэл олон нийтэд тараах зэрэг хууль бус арга хэрэглэж, сонгуулийн хороодын ажилд хөндлөнгөөс оролцвол хэсгийн хороо түүний ажиглагчийн эрхийг хүчингүй болгож, урьд олгосон үнэмлэхийг хураан авна.

45.6.Ажиглагч энэ хуулийн 45.5-д заасны дагуу эрхээ хасуулсан бол түүнийг санал болгосон нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь орны хүнийг томилох эрхгүй бөгөөд ийм хүсэлт гаргавал сонгуулийн хороод хүлээн авахаас татгалзана.

45.7.Сонгуулийг ажиглахтай холбогдсон журмыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

45.8.Нам, эвсэл, нэр дэвшигч, гадаад улсын болон олон улсын байгууллагаас өөр аливаа этгээд ажиглагч томилох, ажиллуулах эрхгүй бөгөөд энэ заалт энэ хуулийн 45.7 дахь заалтад хамаарахгүй.

45.9.Энэ хуулийн 45.5-д заасныг зөрчсөн ажиглагчийг 150000-200000 төгрөгөөр торгоно.

46 дугаар зүйл. Сонгогч саналаа өгөх

46.1. Сонгогч санал авах байранд ирж, саналаа өөрөө өгнө.

46.2. Сонгогч бүр саналын нэг хуудас авч, санал бэлтгэх бүхээгт орж, саналаа нууцаар өгнө.

46.3. Сонгогч нь саналын хуудсанд бичигдсэн, өөрийн сонгохыг хүссэн нэг нам буюу эвслээс нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас зөвхөн нэг нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг, эсхүл нэг бие даан нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг дугуйлж, саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийнэ.

46.4. Сонгогч санал өгөхдөө алдаа гаргаж, саналын хуудсанд буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа санал тоолох төхөөрөмжид хийхээс өмнө энэ тухайгаа хэсгийн хороонд мэдэгдэж, алдаатай хуудсыг шалгуулан хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч, энэ хуулийн 46.3-т заасны дагуу санал өгч болно.

46.5. Хэсгийн хороо энэ хуулийн 46.4-т заасны дагуу хураалгасан саналын хуудсыг тэмдэглэл хөтлөн хадгална.

46.6. Санал бэлтгэх бүхээгт тухайн сонгогчоос өөр хүн байхыг хориглоно.

46.7. Бие эрхтэний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн хүний тусалцаатайгаар санал өгч болох бөгөөд тэр нь сонгуулийн эрх бүхий иргэн байна.

46.8. Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, ухуулагч, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч, сонгуулийн хорооны гишүүн, ажиглагчаар энэ хуулийн 46.7-д заасан үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

46.9. Хэсгийн хороо нь сонгогчийн саналаа нууцаар өгөх эрхэд халдахгүйгээр санал хураалт хуулийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, зөрчил гарвал таслан зогсоох арга хэмжээ авна.

46.10. Санал авах байранд хүрэлцэн ирж чадахгүй дараахь сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн хайрцгаар авна:

46.10.1. биеийн эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр хүрэлцэн ирж чадахгүй;

46.10.2. нийтийн дайчилгаанд хамрагдан ажиллаж буй;

46.10.3. захиргааны зөрчлийн улмаас баривчлагдсан, албадан саатуулагдсан, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан;

46.10.4.байцаан шийтгэх албадлагын арга хэмжээний улмаас баривчлагдсан, цагдан хоригдсон.

46.11.Хэсгийн хороо энэ хуулийн 46.10-т заасан хүсэлтийг үндэслэн зөөврийн битүүмжилсэн хайрцгаар саналыг нь авах сонгогчдын нэрийн жагсаалтыг тусад нь гаргаж, нэрийн жагсаалт, санал авах чиглэл, хуваарийг хуралдаанаараа хэлэлцэн батална.

46.12.Энэ хуулийн 46.11-д заасан сонгогчийн саналыг тухайн хэсгийн хорооны хоёроос доошгүй гишүүн оршин суугаа газрын нь хаягаар очиж авна.

46.13.Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар энэ хуулийн 46.11-д заасан жагсаалтад ороогүй сонгогчийн саналыг авахыг хориглоно.

46.14.Хэсгийн хороо саналын хуудас хүлээн авснаас хойш санал авах өдөр хүртэлх хугацаанд сонгогч түр шилжин явахад хүрвэл хэсгийн хороонд ирж, саналаа нууцаар өгч, дугтуйнд хийж битүүмжлэн үлдээж болно.

46.15.Энэ хуулийн 46.14-т зааснаар урьдчилан санал өгөх тохиолдол бүрт хэсгийн хорооны хоёроос доошгүй гишүүн байлцах ба энэ тухай тэмдэглэл үйлдэж, түүнд байлцсан хэсгийн хорооны гишүүн бүр гарын үсэг зурна.

46.16.Хэсгийн хороо сонгогчийн битүүмжлэн үлдээсэн саналын нууцыг чандлан хадгална.

46.17.Энэ хуулийн 46.10, 46.14-т заасан сонгогчийн саналыг авахад энэ хуулийн 46.1-46.5, 46.7, 46.8-д заасан журмыг баримтална.

46.18.Санал авах өдөр ажиллаж байгаа сонгогчид тухайн байгууллагын захиргаа чөлөө олгож, түүнийг санал өгөх боломжоор заавал хангах үүрэгтэй.

46.19.Энэ хуулийн 46.5, 46.8, 46.12, 46.13, 46.15, 46.16-д заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг 250000-300000 төгрөгөөр, гишүүнийг 200000-250000 төгрөгөөр, 46.6-д заасныг зөрчсөн этгээдийг 150000-200000 төгрөгөөр, 46.18-д заасныг зөрчсөн албан тушаалтныг 250000-300000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 5000000-10000000 төгрөгөөр торгоно.

47 дугаар зүйл.Санал тоолох

47.1.Хэсгийн хэмжээнд нэгдсэн санал тоолох ажиллагааг 20 цагт эхэлж, ил тод, нээлттэй явуулна.

47.2.Санал тоолж, эцсийн дүнг гаргах бэлтгэл хангагдмагц хэсгийн хорооны дарга энэ тухай зарлах ба хэсгийн хороо уг ажиллагааг дараахь журмаар явуулна:

47.2.1.санал авахад зарцуулсан саналын хуудасны тооцоог эцэслэн хийх;

47.2.2.санал авахад зарцуулагдалгүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тоолж, баруун дээд өнцгийг нь хайчлан, энэ тухай тэмдэглэлд тусган боож битүүмжлэх;

47.2.3.энэ хуулийн 47.2.1, 47.2.2-т заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа зөөврийн битүүмжилсэн хайрцгаар болон урьдчилан өгсөн саналыг санал тоолох төхөөрөмжид хийх;

47.2.4.санал тоолж дууссаны дараа санал хураалтын дүнг хэсгийн хэмжээгээр гаргах.

47.3.Санал тоолох төхөөрөмжөөр дараахь үзүүлэлтээр санал хураалтын дүнг гаргана:

47.3.1.сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн тухайн хэсгийн нийт сонгогчийн тоо;

47.3.2.санал өгсөн сонгогчийн тоо,

47.3.3.санал өгсөн нийт сонгогчийн тоо, үүнээс зөөврийн битүүмжилсэн хайрцгаар болон урьдчилан санал өгсөн сонгогчийн тоо;

47.3.4.хүчинтэй болон хүчингүй саналын хуудасны тоо;

47.3.5.нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчийн авсан саналын тоо;

47.3.6.нам, эвслийн авсан саналын тоо.

47.4.Санал авахад зарцуулсан болон зарцуулагдалгүй үлдсэн саналын хуудасны нийлбэр нь тухайн хэсгийн хороо анх хүлээн авсан нийт саналын хуудасны тооноос зөрвөл хэсгийн хороо шалтгааныг шалгаж тогтоох бөгөөд зайлшгүй шаардлага гарвал саналын хуудсыг дахин тоолно.

47.5.Санал тоолох үед энэ хуулийн 47.4-т заасан зөрүү гарвал энэ тухай тэмдэглэл үйлдэж, санал тоолох ажилд оролцогчдоор гарын үсэг зуруулна.

47.6.Санал авахад зарцуулсан саналын хуудасны тоог санал тоолох төхөөрөмжөөс гарсан болон энэ хуулийн 47.2.2-т заасны дагуу хураагдсан саналын хуудасны нийлбэрээр тооцож гаргана.

47.7.Санал тоолох цаг болоогүй байхад санал тоолох төхөөрөмжөөр саналыг тоолуулах, санал тооллогыг завсарлахыг хориглоно.

47.8.Саналын хуудсанд огт тэмдэглэл хийгээгүй, эсхүл бүх нэр дэвшигчийн нэрийг дарсан саналын хуудсыг хүчинтэй саналын хуудаст тооцож, хэнийг ч дэмжээгүй санал гэж үзнэ.

47.9.Хэсгийн хороо хуралдаанаараа санал тоолсон дүнг хэлэлцэн шийдвэр гаргаж, уншиж сонсгосны дараа салбар хороонд, салбар хороогүй бол аймаг, нийслэлийн хороонд нэн даруй хүргүүлнэ.

47.10.Энэ хуулийн 47.1-47.8-д заасан санал тоолох журам зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг 250000-300000 төгрөгөөр, гишүүнийг 200000-250000 төгрөгөөр торгож, гаргасан зөрчил нь ноцтой бол тухайн хорооны бүрэлдэхүүнээс хасна.

48 дугаар зүйл. Саналын хуудсыг хүчингүйд тооцох

48.1.Дор дурдсан тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно:

48.1.1.баталсан загварын бус хуудсаар санал өгсөн;

48.1.2.тухайн хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэггүй, хорооны тэмдэггүй саналын хуудсаар санал өгсөн;

48.1.3.нэгээс илүү нэр дэвшигчийн төлөө санал өгсөн, түүнчлэн энэ хуульд зааснаас өөр тэмдэглэл хийснээс аль нэр дэвшигчид санал өгснийг тодорхойлох боломжгүй болсон;

48.1.4.нэр дэвшигчийн нэрийн өмнө тавьсан дугаарыг засварласнаас аль нэр дэвшигчид санал өгснийг тодорхойлох боломжгүй болсон.

49 дүгээр зүйл. Аймаг, нийслэлд санал хураалтын дүн гаргах

49.1.Аймаг нийслэлийн хороо нь салбар болон хэсгийн хороодоос ирүүлсэн санал хураалтын дүнг энэ хуулийн 47.3-т заасан үзүүлэлтээр нэгтгэж, тухайн аймаг, нийслэлийн санал хураалтын эцсийн дүнг гаргана.

49.2.Нам, эвсэл, нэр дэвшигчийн авсан саналын дүнг саналын хүчинтэй хуудсаар гаргана.

49.3.Аймаг, нийслэлийн хороо санал хураалтын дүнг гурав хоногийн дотор гарган хуралдаанаараа хэлэлцэн шийдвэр гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд хоёр хоногийн дотор хүргүүлнэ.

49.4.Санал хураалтын дүнгийн талаар маргаан гарвал санал авсан өдрөөс хойш аймаг, нийслэлийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ.

50 дугаар зүйл. Сонгуулийн нэгдсэн дүн гаргах, мэдээлэх

50.1.Сонгуулийн ерөнхий хороо аймаг, нийслэлийн хороодоос ирүүлсэн дүн, шийдвэрийг үндэслэн сонгуулийн нэгдсэн дүнг дараахь журмаар гаргана:

50.1.1.улсын хэмжээгээр нийт нэр дэвшигч бүрийн авсан саналыг тооцож нэр дэвшигч тус бүрээр нь нэгтгэн гаргах;

50.1.2.нам, эвсэл бүрийн авсан саналыг тооцож улсын хэмжээгээр нам, эвсэл тус бүрээр нь нэгтгэн гаргах;

50.1.3.нийт хүчинтэй саналын тооноос босго 7 хувийг тооцох;

50.1.4.хэрэв нийт хүчинтэй саналын 7-оос дээш хувийн саналыг бие даан нэр дэвшигч авсан бол түүнийг сонгогдсонд тооцох.

50.2.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 50.1.2-т заасан босгыг давсан нам, эвсэлд ногдох суудлыг тухайн нам, эвслийн авсан саналын тоотой хувь тэнцүүлэн дараахь байдлаар хуваарилна:

50.2.1.энэ хуулийн 50.1.2-т заасан босгыг даваагүй нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчдийн саналыг хүчингүйд тооцохгүйгээр хүчинтэй саналын тооноос хасч, гарсан дүнг 76-д хувааж нэг суудалд ногдох саналын тоог гаргах;

50.2.2.энэ хуулийн 50.1.2-т заасан босго давсан нам, эвсэл тус бүрийн нэр дэвшигчдийн авсан саналын тоог нэг суудалд ногдох саналын тоонд хувааж тэдгээр нам, эвсэл тус бүрийн авсан суудлын тоог тогтоох.

50.3. Энэ хуулийн 50.2-т заасан журмаар суудал хуваарилсны дараа сул суудал үлдвэл эдгээр нам, эвслийн хамгийн их үлдэгдэл саналтай байгаа нам, эвслээс эхлэн /их үлдэгдэл саналын зарчмаар/ хуваарилж дуусгана.

50.4.Хэрэв энэ хуулийн 50.1.3-т заасны дагуу бие даан нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон бол түүний Улсын Их Хурлын гишүүний суудлыг Улсын Их Хурлын нийт гишүүний суудлын тооноос хасч тооцсоны дараа мөн хуулийн 50.2.1, 51.2.2-т заасан журмаар нам, эвсэл, тус бүрт ногдох суудлын тоог тогтоож, тэдгээрээс сонгогчдын саналын тоогоор жагсаалтын эхэнд бичигдсэнээс эхлэн авсан суудалтай нь тэнцүү тооны хүнийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.

50.5.Нам, эвсэлд, бие даан нэр дэвшигчид суудал хуваарилж гүйцсэний дараа суудал авсан тоо нам, эвсэл тус бүрийн нэр дэвшигчдийн авсан хүчинтэй саналыг олноос цөөн рүү нь дараалуулан жагсааж гаргана.

50.6.Суудал хуваарилагдсан бие даан нэр дэвшигчийг болон энэ хуулийн 50.5-д заасан жагсаалтаар хамгийн олон санал авснаас нь дараалуулан тухайн нам, эвслийн авсан суудлын тоогоор түүний нэр дэвшигчдийг Улсын Их Хурлын гишүүнээр бүртгэж түр үнэмлэх олгоно.

50.7.Сонгуулийн ерөнхий хороо нам, эвслийн авсан суудлын тоо, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдогчдын нэрийн жагсаалтыг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор гаргаж, Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган нийтэд мэдээлнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ

**Санал хураалт болон сонгуулийг хүчингүйд тооцох,
дахин санал хураах, дахин сонгууль явуулах,
Улсын Их Хурлын гишүүнийг нөхөн сонгох**

**51 дүгээр зүйл.Сонгуулийг хүчингүйд тооцох, дахин сонгууль явуулах
шийдвэр гаргах**

51.1.Нийт сонгогчийн 50 хувь нь санал хураалтад оролцоогүй бол Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийг бүхэлд нь хүчингүй болсонд тооцох тухай асуудлыг шийдвэрлүүлэхээр санал хураалт дууссан өдрөөс хойш 15 хоногийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

51.2. Улсын Их Хурал энэ хуулийн 51.1-д заасан асуудлыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хэлэлцэх бөгөөд сонгуулийг хүчингүйд тооцсон бол ийнхүү шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор дахин сонгууль товлон зарлана.

51.3.Энэ хуулийн 51.2-т заасны дагуу дахин сонгууль явуулахад шаардлагатай бол аймаг, нийслэлийн болон хэсгийн хороог шинэчлэн байгуулах, түүнчлэн Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх зэрэг уг сонгуулийг бэлтгэн явуулах ажилд энэ хуулийн холбогдох заалтыг баримтална.

52 дугаар зүйл.Хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцох, дахин санал хураах

52.1.Аймаг, нийслэлийн хороо дор дурдсан тохиолдолд хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцно:

52.1.1.гамшиг, гэнэтийн бусад аюулт үзэгдэл тохиолдсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад урьд нь зарласнаас өөр байранд, түүнчлэн шилжсэн сонгогчдын саналыг битүүмжилж авснаас бусад тохиолдолд санал хураахаар зарласнаас өөр өдөр санал авсан;

52.1.2.санал хурааж эхэлснээс хойш санал тоолох төхөөрөмж, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, эсхүл хуульд заасан цагаас өмнө түүнийг нээсэн;

52.1.3.сонгуулийн хорооны гишүүн буюу сонгогчид хүч хэрэглэн дарамт үзүүлсэн аливаа үйлдэл нь сонгогчийн санал, санал хураалтын дүнг гажуудуулахад хүргэсэн;

52.1.4.сонгуулийн хороодын гишүүн, бусад байгууллагын албан тушаалтан энэ хуулийн 18, 21, 22, 44, 46, 47 дугаар зүйлд заасан сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, сонгогч шилжих, сонгогчийн үнэмлэх олгох, санал авах ажиллагааг зохион байгуулах, сонгогч санал өгөх, санал тоолох журмыг зөрчсөн нь хэсгийн сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр байвал.

52.2.Санал хураалтыг хүчингүйд тооцвол энэ тухай шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор дахин санал хураалт явуулна.

52.3.Дахин санал хураах шийдвэрийг аймаг, нийслэлийн хороо гаргах бөгөөд уг шийдвэрт санал авах байр, өдрийг заах ба түүнийг ажлын өдөр явуулж болно.

52.4.Санал хураалтыг хэсгийн хэмжээгээр хүчингүйд тооцсон бол тухайн хэсгийн нийт сонгогч, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар хураасан саналыг

хүчингүйд тооцсон бол уг хайрцагт саналаа өгсөн сонгогчдыг дахин санал хураалтад оролцуулна.

52.5. Дахин санал хураах ажиллагааг дуустал сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно.

52.6. Энэ хуулийн 52.5-д заасныг зөрчсөн ухуулагч, шадар туслагч, дэмжигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтныг 200000-250000 төгрөгөөр, албан тушаалтныг 250000-300000 төгрөгөөр, нам, эвсэл, бусад байгууллагыг 5000000-10000000 төгрөгөөр торгоно.

53 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний орон гарсан суудлыг нөхөх

53.1. Улсын Их Хурлын гишүүн нас барсан, түүнчлэн өөр ажилд шилжих, эрүүл мэндийн байдал зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эсхүл түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татсан бол Улсын Их Хурлын гишүүний орон гарсан суудалд энэ хуулийн 50.5-т заасан жагсаалтын дараагийн дэс дугаарт эрэмблэгдсэн нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.

53.2. Хэрэв энэ хуулийн 53.1-д заасан шалтгаанаар бие даан нэрээ дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний орон гарсан суудалд түүний оронд өөр хүнийг нөхөн сонгохгүй.

53.3. Энэ хуулийн 53.1-д зааснаар Улсын Их Хуралд орон гарсан суудалд суух Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх саналыг Сонгуулийн ерөнхий хороо Улсын Их Хуралд танилцуулна.

53.4. Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ **Сонгуулийн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, гомдол, маргаан шийдвэрлэх харъяалал, журам**

54 дүгээр зүйл. Сонгуулийн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

54.1. Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

54.2. Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

54.3. Сонгуулийн үйл ажиллагааны явцад хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

54.4. Энэ хуульд заасан зөрчил гаргаж захиргааны хариуцлага хүлээсэн нь уг этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

55 дугаар зүйл. Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг шийдвэрлэх харъяалал

55.1. Энэ хуульд сонгуулийн хороод харъяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргана.

55.2. Энэ хуульд заасан захиргааны шийтгэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба түүнд давж заалдсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу сум буюу сум дундын, дүүргийн шүүх хянан шийдвэрлэнэ.

55.3. Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд Эрүүгийн болон Иргэний хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журам, харъяаллын дагуу шийдвэрлэнэ.

56 дугаар зүйл. Сонгуулийн хэсгийн хороо хянан шийдвэрлэх гомдол, маргаан

56.1. Сонгуулийн хэсгийн хороо дараахь гомдол, маргааныг хянан шийдвэрлэнэ:

56.1.1.энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан сонгогчийг нэрийн жагсаалтад бүртгээгүй буюу буруу бүртгэсэн тухай гомдол;

56.1.2.энэ хуулийн 36.12, 36.15-д заасан үйлдэл, үйл ажиллагаа явуулсан тухай мэдээлэл, гомдол;

56.1.3.ажиглагч энэ хуулийн 45.5 дахь хэсэгт заасан зөрчил гаргасан тухай гомдол;

56.1.4.энэ хуулийн 47.9-д заасан хуралдаанд санал хураалтын талаар гаргасан гомдол, маргаан.

56.2. Хэсгийн хороо энэ зүйлийн 56.1.1-д заасан гомдлыг нэн даруй, гэхдээ санал хураах өдрөөс оройтуулахгүйгээр, 56.1.2, 56.1.3-т заасан гомдлыг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор, 56.1.4-т заасан гомдлыг ажлын нэг өдрийн дотор тус тус шалган шийдвэрлэж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг өөрийн бүрэн эрхийн хүрээнд авч, энэ хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэх асуудлыг шүүхэд, нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах асуудлыг аймаг, нийслэлийн хороонд нэн даруй тавина.

57 дугаар зүйл. Сонгуулийн аймаг, нийслэлийн хороо хянан шийдвэрлэх гомдол, маргаан

57.1. Сонгуулийн аймаг, нийслэлийн хороо дараахь гомдол, маргааныг хянан шийдвэрлэнэ:

57.1.1. энэ хуулийн 56.1-д заасан гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн хэсгийн хорооны шийдвэрийн талаар гаргасан гомдол;

57.1.2. энэ хуулийн 40.7, 40.8 дахь заалтыг зөрчсөн тухай мэдээлэл, гомдол;

57.1.3. санал хураалтын дүнг аймаг, нийслэлийн хороонд хүлээн авснаас хойш түүнтэй холбогдуулан гаргасан маргаан, гомдол.

57.2. Аймаг, нийслэлийн хороо энэ зүйлийн 57.1-д заасан гомдол, маргааныг хойшлуулшгүйгээр, гэхдээ 14 хоногийн дотор шалган шийдвэрлэнэ.

57.3. Энэ хуульд заасан сонгогчдын нэрийн жагсаалтын талаархи гомдол болон хэсэгт явагдсан санал хураалтын дүнгийн талаархи маргааныг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн хорооны шийдвэр эцсийн байна.

58 дугаар зүйл. Сонгуулийн ерөнхий хорооны хянан шийдвэрлэх маргаан

58.1. Сонгуулийн ерөнхий хороо дараахь гомдол, маргааныг хянан шийдвэрлэнэ:

58.1.1. нам, эвслийг бүртгэсэн, түүнчлэн бүртгэхээс татгалзсантай холбогдуулан гаргасан гомдол;

58.1.2. санал хураалтыг хүчингүйд тооцох асуудлаар гаргасан аймаг, нийслэлийн хорооны шийдвэр хууль зөрчсөн тухай гомдол, маргаан;

58.1.3. энэ хуульд заасан үндэслэлээр нэр дэвшигчийг бүртгэсэн болон бүртгэхээс татгалзсан асуудлаар гаргасан аймаг, нийслэлийн хорооны шийдвэртэй холбогдох гомдол, маргаан;

58.1.4. нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах асуудлаар гаргасан аймаг, нийслэлийн хорооны шийдвэртэй холбогдох гомдол, маргаан.

58.2. Сонгуулийн ерөнхий хороо энэ зүйлийн 58.1.1-д заасан гомдлыг гурав хоногийн хугацаанд, 58.1.2-т заасан гомдол, маргааныг хүлээн авснаас хойш ажлын гурав хоногийн дотор, 58.1.3-т заасан маргааныг нэн даруй, гэхдээ гомдол, маргааныг хүлээн авснаас хойш тав хоногийн дотор, 58.1.4-т заасан маргааныг нэн даруй, гэхдээ хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тус тус хянан шийдвэрлэнэ.

58.3. Сонгуулийн ерөнхий хорооноос энэ зүйлийн 58.1.2, 58.1.3, 58.1.4-т заасан асуудлаар гаргасан шийдвэр эцсийн байна.

58.4. Сонгуулийн ерөнхий хороо нь шаардлагатай гэж үзвэл энэ зүйлд дурьдсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх хүртэл хугацаанд доод шатны хорооны шийдвэрийг түдгэлзүүлэх эрхтэй.

59 дүгээр зүйл. Сонгуулийн хороодын үйл ажиллагаатай холбогдох бусад маргааныг хянан шийдвэрлэх

59.1. Хуульд өөрөөр заагаагүй бол сонгуулийн зохион байгуулалтын асуудлаар гаргасан хэсгийн болон салбар хорооны шийдвэрийн талаар аймаг, нийслэлийн хороонд, аймаг, нийслэлийн хорооны шийдвэрийн талаар Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргаж болох бөгөөд зохих шатны хороо гомдлыг хүлээж авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ Бусад асуудал

60 дугаар зүйл. Сонгуулийн үйл ажиллагааг автоматжуулах

60.1. Сонгуулийн үйл ажиллагааны явцад сонгуулийн хороодын ажлыг хөнгөвчилж автоматжуулах, сонгогчдын нэрийн жагсаалтыг хянан нягтлах, сонгуулийн явцын мэдээллийг үнэн зөв, шуурхай гаргах, санал тоолох ажиллагаанд хүний хүчин зүйлсийн сөрөг нөлөөллийг арилгах, ажиглагчдад ил тод болгох зорилгоор сонгуулийн тодорхой үе шатны ажиллагаанд холбоо, мэдээллийн техник, технологийг ашиглах асуудлыг Сонгуулийн ерөнхий хороо шийдвэрлэнэ.

60.2. Сонгуулийн ерөнхий хороо санал тоолох, дүнг гаргах ажиллагаанд ашиглах холбоо, мэдээллийн техник, технологийн шийдлийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж зөвшилцөнө.

60.3. Сонгуулийн үйл ажиллагаанд холбоо, мэдээллийн техник, технологи ашиглахтай холбогдон гарах шаардагдах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал ээлжит сонгуулийн өмнөх жилийн улсын төсөвт тусган батална.

61 дүгээр зүйл. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах

61.1. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнө зургаан сарын дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах буюу түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

62 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

62.1. Энэ хуулийг оны сарын-ны өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

Гарын үсэг